# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ


Долоо хоног тутмын хэвлэл
2010 оны 09 дүгээр сарын 20
№35 /656/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ


Монгол Улсын Их Хурлын тогтоол

1422

## Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тогтоол

1465

## Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдсаны 20 жилийн ойг тэмдэглэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт

1466

## Банкны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай


Улаанбаатар хот
2010 он

Улсын Их Хурлын Тамгын Газар

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

313. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Дугаар 45 1422

314. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 46 1465

315. Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдсаны 20 жилийн ойг тэмдэглэх тухай Дугаар 47 1465

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

316. Банкны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 03 1466

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2011 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан, хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/, Монголбанк /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тулгуурлан 2011 оны төсвийн төслийг боловсруулж Улсын Их Хурлаар батлуулахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

4.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж, хэрэгжилтийн явцыг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Д.ДЭМБЭРЭЛ**

**Монгол Улсын Их Хурлын 2010 оны
45 дугаар тогтоолын хавсралт**

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2011 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Д/д | Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг | Зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2011 онд хүрэх түвшин, үр дүн | Хөрөнгийн эх үүсвэр /тэрбум төгрөг/ | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | |
| Зорилт-1. Макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүний хөгжлийг хангахад чиглүүлнэ. | | | | | | |
| 1.1 | "Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр" /цаашид "ЗГҮАХ" гэх/-ийн 2.1.6 дахь заалт | Уул уурхайн томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, хүний хөгжлийг хангах | Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт | 8.2 хувь | - | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /цаашид "ЗГХЭГ" гэх/ |
| | | | Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ | 2,076.5 ам.доллар | - | ЗГХЭГ |
| | | | Хүний хөгжлийн индекс, нэгж | 0.758 нэгж | - | ЗГХЭГ, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам /цаашид "НХХЯ" гэх/ |
| | | | Ажилгүйдлийн түвшин, хувь | 2.9 хувиас илүүгүй байна | - | НХХЯ |
| 1.2 | ЗГҮАХ-ийн 2.1.12 дахь заалт | Хүн амын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн зохистой байдлыг хадгалж, нийлүүлэлтийг тогтворжуулж, инфляцийн түвшинг өсөхгүй байх бодлогыг баримтлах | Инфляцийн зорилтот түвшин, жилийн эцэст, хувь | 9.7 хувиас илүүгүй | - | ЗГХЭГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.3 | ЗГҮАХ-ийн 2.3.2, 4.3.5 дахь заалт | Боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны эргэлтийг сайжруулах | Хүчин чадлыг нь нэмэгдүүлэх боомтын тоо | 6 | 30.0 Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗГХЭГ, Гадаад харилцааны яам /цаашид "ГХЯ" гэх/, Сангийн яам /цаашид "СЯ" гэх/, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам /цаашид "ЗТБХБЯ" гэх/ |
| 1.4 | ЗГҮАХ-ийн 2.1.2 дахь заалт | Төсвийн цэнэгтэлийг үргэлжүүлж, санхүүгийн хувьд орон нутгийн биеэ даасан байдлыг бэхжүүлэх | Төсвийн тухай хуулийг батлуулах, хэрэгжүүлж эхлэх | Хууль хэрэгжиж эхэлсэн байна | - | СЯ |
| 1.5 | ЗГҮАХ -ийн 2.1.7 дахь заалт | Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн орлого, зарлагын эзлэх хэмжээг жил бүр бууруулах бодлого баримтлах | Дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн нийт орлогын эзлэх хувь | 35.4 | - | СЯ |
| | | | Дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн нийт зарлагын эзлэх хувь | 40.4 | - | СЯ |
| | | | Дотоодын нийт бүтээгдэхүүнд төсвийн алдагдлын эзлэх хувь | 5.0 | - | СЯ |
| 1.6 | | Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу байгуулагдах стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрлийг эзэмших хуулийн этгээдийн хувьцааг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.7 | | Төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжоотой эх үүсвэрийг бүрэн дайчлах, төсвийн үргүй зардлыг багасгах болон төсвийн, төрийн сангийн хөрөнгийг арилжааны банкинд байршуулах, хадгалуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төсвийн хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлж, тэргүүлэх чиглэлүүдэд төвлөрүүлэх, үр өгөөжтэй хөгжлийн томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах чиглэлээр төсвийн шинэчлэл хийх | | | | СЯ |
| 1.8 | | Татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, орон нутгийн татварын тогтолцоог бий болгох, татвар хураалт, хувь хүний орлогын албан татварын тогтолцоог боловсронгуй болгох, татвар төлөгчдийн татвар төлөх хийгмийн сэтгэл зүйг хөгжүүлэн татварт хамрагдах түвшинг дээшлүүлэх, бэлэн ба бэлэн бус төлбөр тооцоог бүртгэлжүүлэх, далд эдийн засгийн нөлөөллийг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэх, татвар тэгш, шударга байх зарчмыг баримтлах, мэдээллийн тогтолцоог сайжруулах | | | | СЯ |
| 1.9 | | Ашигт малтмал олборлох, боруулах, экспортлоход төрөөс тавих хяналтыг боловсронгуй болгох, ашигт малтмалыг аль болох нэмүү өртөг шингээж экспортлох бодлого баримтлах, ашигт | | | | ЭБЭХЯ, СЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | малтмалын нөөцийг ашиглахтай холбогдсон албан татвар, төлбөр, хураамжийг бүрэнногдуулж хураах, түүнд татварын албанаас тавих хяналтыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | | | | |
| 1.10 | | "Гаалийн шинэчлэл" төслийг үргэлжлүүлэн гаалийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулах, эрсдэлийн удирдлагад тулгуурласан гаалийн хяналтыг хэрэгжүүлэх, гаалийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгох, гаалийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шуурхай хүргэх, шат дамжлагыг цөөлөх, хууль бус суртлыг арилгах, хилийн нэгдсэн менежмент болон гадаад худалдааны үндэсний цахим нэг цонхны үйлчилгээний тогтолцоог бий болгох | | | | СЯ |
| 1.11 | | Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Транзит Монгол" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хилийн боомтуудыг өргөтгөн тохижуулж, хяналтыг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх, ложистик терминал барих, хилийн боомтод ажиллах гаалийн улсын байцаагчдын ажиллах нөхцөл, орон сууцны асуудлыг шийдвэрлэх, хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг сайжруулах үүднээс улсын хилээр ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэлд стандарт тогтоож мөрдүүлэх | | | | ЗГХЭГ, СЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.12 | | Монгол Улсын ээлжит зэрэглэлийг жил бүр шинэчлэн тогтоолгох чиглэлээр олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай хамтран ажиллах | | | | СЯ |
| Зорилт-2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дээшлүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэнэ. | | | | | | |
| 2.1 | "Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ийн 5.1.3 /цаашид "ҮХЦБ" гэх/ дахь заалт | Хөрөнгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | Шинээр боловсруулж батлуулах хуулийн төслийн тоо | 7 | - | СЯ, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "СЗХ" гэх/ |
| 2.2 | ЗГҮАХ-ийн 2.1.22 дахь заалт | Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг боловсронгуй болгож, Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг олон улсын түвшинд ойртуулан хөгжүүлэх | Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх | - | - | СЯ, СЗХ, ЗГХЭГ |
| 2.3 | ЗГҮАХ-ийн 2.1.22 дахь заалт | Монголын хөрөнгийн зах зээлд гадаадын үнэт цаасыг бүртгэх, арилжаалах эрх зүйн орчныг бий болгох | Шинээр боловсруулж батлуулах хуулийн төслийн тоо | 1 | - | СЯ |
| 2.4 | ҮХЦБ-ын 5.1.3 дахь заалт | Стратегийн ач холбогдол бүхий орд газрын ашиглалтын лиценз эзэмшигчид хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж, арилжаалах ажиллагаа эхлүүлэх | Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх аж ахуйн нэгжийн тоо | 5 хүртэл | - | Эрдэс баялаг, эрчим хүчний яам /цаашид "ЭБЭХЯ" гэх/, СЯ, ЗГХЭГ |
| 2.5 | ЗГҮАХ-ийн 2.1.24 дэх заалт | Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгоор жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, зээлийн батлан даалтын тогтолцоог бүрдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх | Зээлийн батлан даалтад хамрагдах аж ахуйн нэгжийн тоо<br>Зээлийн эх үүсвэрийн нэмэгдэх хэмжээ, тэрбум төгрөг | 80-аас доошгүй<br><br>30.0 хүртэл | 2.0 гадаад эх үүсвэр<br><br>30.0 Японы хөнгөлөлттэй зээл | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /цаашид "ХХААХҮЯ" гэх/,<br>СЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | ЗГҮАХ-ийн 2.1.19 дэх заалт | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг хөрөнгө оруулалтад ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх | Шинээр хийх судалгааны тоо | 1 | Тусламж | СЯ |
| 2.7 | | Үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих зорилгоор нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх | | | | ЗГХЭГ |
| 2.8 | | Гадаадын зээл, тусламж, дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, менежментийг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох | | | | СЯ |
| 2.9 | | Олон улсын санхүүгийн зах зээл дээр Монгол Улсын Засгийн газрын бондыг арилжаалах, Монгол Улсын жишиг хүүг тогтоох, өмнө нь арилжаалсан бондын эрсдэлийг удирдан, эргэн төлөлтийг гүйцэтгэх, бонд гаргах, бондын зориулалт, хугацаатай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох | | | | СЯ |
| 2.10 | | Даатгалын зах зээлийн хөгжлийг дэмжиж, түүний нийгэмд үзүүлэх үр нөлөөг өргөжүүлэх хүрээнд "Малын индексжүүлсэн даатгал" төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн бүх аймагт нэвтрүүлэх, улмаар уг даатгалд иргэд сайн дураараа хамрагдах боломжийг бүрдүүлэх | | | | СЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ХОЁР. БОДИТ САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЖ, ХҮНИЙ АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ** | | | | | | |
| **Зорилт-3. Бодит салбарын хөгжлийг дэмжиж, өндөр технологийн аж үйлдвэрийг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 3.1 | ЗГҮАХ-ийн 2.2.3 дахь заалт | Оюу толгой төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх. Таван толгой төслийг хэрэгжүүлж эхлүүлэх бэлтгэлийг хангах, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | Дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь | 35.7 | - | ЭБЭХЯ |
| 3.2 | ЗГҮАХ-ийн 2.2.32 дахь заалт | Зэсийн баяжмалыг боловсруулж, цэвэр зэс гаргах үйлдвэрийг барьж эхлэх | Барилгын ажлын гүйцэтгэл | 20 хувь | 200.0 бусад эх үүсвэр | ЭБЭХЯ, ЗГХЭГ |
| 3.3 | Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого | "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолборыг барьж эхлэх | Цогцолборт шинээр байгуулж эхлэх үйлдвэрийн тоо | 3 хүртэл | 780.0 Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗГХЭГ, СЯ, ЗТБХБЯ, ЭБЭХЯ, Байгаль орчин, аялал, жуулчлалын яам /цаашид "БОАЖЯ" гэх/, ХХААХҮЯ |
| 3.4 | ЗГҮАХ-ийн 2.2.8.1 дэх заалт, ҮХЦБ-ын 5.3.3.1 дэх заалт | Нүүрснээс эрчим хүч үйлдвэрлэн экспортлох, хий, шингэрүүлсэн түлш гаргах үйлдвэр байгуулах судалгааг хийж, уг судалгааг эхлүүлэх бэлтгэлийг хангах | Судалгаа хийх ажлын явц | 100 хувь | 5.0 БНСУ | ЭБЭХЯ |
| 3.5 | ЗГҮАХ-ийн 2.2.22.4 дэх заалт | Тамсаг болон Дорноговийн сав газарт газрын тос олборлож эхэлж байгаатай холбогдуулан бүтээгдэхүүн хуваах гэрээнд өөрчлөлт оруулах, олборлолт, | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100 хувь | - | ЭБЭХЯ ЗТБХБЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | борлуулалтад тереес тавих хяналтыг сайжруулах, цаашид газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангаж, төслийг хэрэгжүүлж эхлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тухайн аймаг, сумдад дэд бүтэц барьж байгуулах | | | | |
| 3.6 | ЗГҮАХ-ийн 2.2.8.11 дэх заалт | Замын-Үүдийн шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийг өргөтгөх | Шинээр нэмэгдэх хүчин чадал | 16 мянган $м^3$ | 5.3 Улсын төсөв | ЭБЭХЯ |
| 3.7 | ЗГҮАХ-ийн 2.2.35 дахь заалт, ҮХЦБ-ын 5.2.1.2 дахь заалт | Дарханы төмөрлөгийн үйлдвэрт металл цувимал үйлдвэрлэх | Үйлдвэрлэх цувималын хэмжээ | 500 мянган тонн хүртэл | 300.0 Гадаадын хөрөнгө оруулалт | ЭБЭХЯ |
| 3.8 | ЗГҮАХ-ийн 2.2.35.2 дахь заалт | Дархан, Сэлэнгийн бүс нутагт Төмөртэй, Хустай, Баянгол, Төмөр толгой зэрэг төмрийн хүдрийн орд газруудыг түшиглэн хар металлургийн үйлдвэрийн цогцолбор байгуулах гэрээ, хэлэлцээ хийх, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, төмрийн хүдрийг олборлох, баяжуулах үйл ажиллагаар Улсын Их Хуралд танилцуулж, эхлүүлэх | Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын явц | 100 хувь | 1.0 Улсын төсөв | ЭБЭХЯ |
| 3.9 | ЗГҮАХ-ийн 2.2.6 дахь заалт | Өндөр бүтээмж, дэвшилтэт технологи бүхий барилгын материалын үйлдвэрийг байгуулах, сорилт туршилтын лабораторууд шинээр байгуулах | Шинээр байгуулах үйлдвэрийн тоо<br><br>Шинээр байгуулах лабораторийн тоо | 1<br><br>5 | 38.0 Гадаадын хөрөнгө оруулалт<br><br>1.0 Улсын төсөв | ЗТБХБЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.10 | ЗГҮАХ-ийн 1.2.29, 1.2.31 дэх заалт | Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хөгжлийн хандлагатай уялдуулан шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг хөгжүүлэх | Эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн өрсөлдөх чадвар бүхий технологийн судалгааны тоо | 30-аас доошгүй | 1.0 Улсын төсөв | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /цаашид "БСШУЯ" гэх/ |
| 3.11 | ЗГҮАХ-ийн 2.1.9.2 дахь заалт | Чойрт аж үйлдвэрийн парк байгуулах судалгаа хийх | Үйл ажиллагааны хэрэгжилт | - | - | ХХААХҮЯ, ЭБЭХЯ |
| 3.12 | | Уул уурхайн салбарын эдийн засгийн удирдлага, хяналт, зохицуулалтын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх | | | | ЭБЭХЯ |
| 3.13 | | Дорноговь аймгийн Өргөн сумын Өвдөг худгийн шохойн ордыг түшиглүүлэн цементийн үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх | | | | ЗТБХБЯ |
| 3.14 | | "Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх | Холбогдох хууль тогтоомжийг боловсруулах, 2-оос доошгүй төв болон лаборатор байгуулах | | 2.0 Улсын төсөв 2.0 зээл, тусламж | ЗГХЭГ |
| 3.15 | | Түлш, эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, зах зээлийн зарчмаар ажиллуулах асуудлыг шийдвэрлэх | | | | ЭБЭХЯ |
| 3.16 | | Асгатын мөнгө, холимог металлын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол, Оросын хамтарсан "Монросцветмет" нэгдлийн шугамаар хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх, уг ордод үйлдвэр | | | | ЭБЭХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах арга хэлбэрийг тогтоож, төслийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх | | | | |
| 3.17 | | Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, олон улс, бүс нутгийн хэмжээнд эрчим хүчний интеграцийн бодлогод оролцох, эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох зорилтын хүрээнд "Эрчим хүч - түүхий эдийн үйлдвэрлэл" хөтөлбөр хэрэгжүүлэх | | | | ЭБЭХЯ |
| 3.18 | | "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтийг хангах, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх | | | | ЗГХЭГ |
| 3.19 | | Алтны олборлолт, борлуулалтаас төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх бодлогыг баримтлах, энэ салбарт бий болсон далд эдийн засгийг бууруулах чиглэлд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох | | | | СЯ, ЭБЭХЯ |
| 3.20 | | "Бизнесийн орчны шинэтгэл"-ийн хүрээнд төрөөс үзүүлж байгаа бүх төрлийн үйлчилгээ, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, гаргаж байгаа шийдвэр, тавьж байгаа хяналт, бусад шат дамжлагыг судалж, эрх зүйн орчныг нь сайжруулах, төрөлжсөн мэдээллийн технологийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх, төрийн зарим үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх | | | | ЗГХЭГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.21 | | Дархан-Уул аймагт жилдээ 2 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар болон хувийн хэвшлийн компаниудын оролцоотой консорциум байгуулж, үйлдвэрийг барьж эхлүүлэх | | | | ЭБЭХЯ |
| 3.22 | | Төв аймгийн Зуунмод суманд аж үйлдвэрийн парк барих ажлыг эхлүүлэх | | | | ЗГХЭГ, ЭБЭХЯ Тэргүүн шадар сайдын ажлын алба |
| **Зорилт-4. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн салбарыг хөгжүүлж, малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 4.1 | ЗГҮАХ-ийн 2.3.13 дахь заалт | Хөдөөгийн хүн ам, мал, амьтны усан хангамжийг сайжруулах, шинэ худаг гаргах | Шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн тоо | 1000 хүртэл | 3.0 Улсын төсөв | ХХААХҮЯ |
| | | | Усжуулах бэлчээрийн хэмжээ | 8.4 мянган га | 0.3 Улсын төсөв | ХХААХҮЯ |
| 4.2 | ЗГҮАХ-ийн 2.3.11 дэх заалт | Аймаг дундын отрын бэлчээрийг хашиж хамгаалах, өргөтгөх | Хашиж хамгаалах газрын хэмжээ | 70 мянган га | 0.6 Улсын төсөв | ХХААХҮЯ |
| | | | Шинээр байгуулах отрын бүсийн тоо | 2 | 0.05 Улсын төсөв | ХХААХҮЯ |
| 4.3 | ЗГҮАХ-ийн 2.3.6, 2.3.12 дахь заалт Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого | "Монгол мал" үндэсний хөтөлбөрт заасны дагуу малын чанарыг сайжруулах, малыг эрүүлжүүлэх, малчдын орлогын тогтвортой өсөлтийг хангах зорилгоор нэмүү өртөг шингээсэн, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үндэсний хэмжээний тэргүүлэх ач холбогдол бүхий үйлдвэрлэлийг | Малын ашиг шимийн нэмэгдэл<br><br>Вакцинжуулалтад хамрагдах малын тоо, сая толгой | 3 хувь<br><br>36 сая толгой | 150.0 Улсын төсөв, гадаадын зээл | ХХААХҮЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хөгжүүлэх, энэ чиглэлээр жижиг, дунд, үйлдвэрлэл, сүү, мах, ноос, ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлж, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийг бүсийн төвүүдэд байгуулах, тэдгээрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, эдгээр салбарт төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх | | | | |
| 4.4 | | "Монгол мал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд мал аж ахуйн салбарт олон улсын стандартын шаардлагыг хангасан эрүүл ахуй, чанарын хяналтын тогтолцоог нэвтрүүлж мал аж ахуйн гаралтай хүнс, түүхий эд болон бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг 40-өөс доошгүй хувиар нэмэгдүүлэхийн тулд хоёр хөрш, бусад хэлэлцээр хийсэн орнуудтай хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хорио цээрийн хэлэлцээрийг байгуулж, холбогдох шаардлага, болзол, нөхцөлийг бүрдүүлэх | 40-өөс доошгүй хувь | | | ХХААХҮЯ |
| 4.5 | | Зудаар малгүй болсон малчдыг малжуулах арга хэмжээг үргэлжлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт | - | 3.0 Улсын төсөв, 7.0 Гадаадын зээл, тусламж | ХХААХҮЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.6 | | Эрчимжсэн мал аж ахуйн загвар аж ахуйг бий болгох, цөм сүргийн үржлийн аж ахуйнуудыг бэхжүүлэх | Шинээр бий болох загвар аж ахуйн тоо<br>Цөм сүргийн тооны өсөлт | 20<br>15 мянган толгой | 4.0<br>бусад эх үүсвэрээс | ХХААХҮЯ |
| 4.7 | ЗГҮАХ-ийн 2.3.5, 2.3.17 дахь заалт | Усалгаатай газар тариаланг дэмжиж, техник, технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногоо, хадлан тэжээл бэлтгэх хүчин чадлыг нэмэгдүүлэх | Шинээр нэмэгдэх усалгаатай талбайн хэмжээ<br>Хураан авах ургацын хэмжээ<br>Үр тариа<br>Төмс, хүнсний ногоо<br>Тэжээлийн ургамал | 5.5 мянган га<br>454 мянган тонн<br>205 мянган тонн<br>170 мянган тонн<br>52 мянган тонн | 2.0<br>Улсын төсөв<br>10.0<br>бусад эх үүсвэрээс | ХХААХҮЯ |
| 4.8 | ЗГҮАХ-ийн 2.3.5 дахь заалт Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого | Үрийн сорт, нэр төрлийг олшруулах, үрийн чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | Дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжийн тоо | 10 хүртэл | 12.0<br>Улсын төсөв | ХХААХҮЯ |
| 4.9 | ЗГҮАХ-ийн 2.2.30 дахь заалт "Чацаргана" хөтөлбөр | Чацаргана болон бусад жимс, жимсгэний суулгац бэлтгэх, тариалах, боловсруулах үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх | Тариалах талбайн хэмжээ<br>Жимс, жимсгэний дотоодын хангамж | 5 хүртэл мянган га<br>10 хувь | 1.0<br>Улсын төсөв | ХХААХҮЯ |
| 4.10 | ЗГҮАХ-ийн 2.3.5 дахь заалт | Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд "Халх гол" төслийг хэрэгжүүлэх | Төслийг хэрэгжүүлж эхлэх | Төсөл хэрэгжиж эхэлсэн байна | Хувийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламж | ХХААХҮЯ |
| 4.11 | | Малын тэжээлийн үйлдвэрүүдийг барьж байгуулах, өвс тэжээлийн нөөцийн санг дэмжих | | | | ХХААХҮЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.12 | | Малчдад бага оврын 8000, тариалан эрхлэгчдэд бага оврын 12000 тракторыг дагалдах тоног төхөөрөмжийн хамт хөнгөлөлттэй үнээр олгох, том, дунд оврын техникийн лизингийн үйлчилгээ нэвтрүүлэх, бага оврын трактор, тээврийн хэрэгсэл, дагалдах тоног төхөөрөмжийг дотоодод үйлдвэрлэж, угсрах | | | | ХХААХҮЯ |
| **Зорилт-5. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг үе шаттайгаар эрчимжүүлж, хүн амыг аюулгүй, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнээр хангана.** | | | | | | |
| 5.1 | ЗГҮАХ-ийн 2.1.28 дахь заалт | Европын Холбооны стандартыг нутагшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Европын Холбооны стандартын түвшинд хүрсэн үндэсний стандартын эзлэх хувь | 45 | - | Тэргүүн Шадар сайдын ажлын алба |
| 5.2 | ЗГҮАХ-ийн 2.2.5 дахь заалт | Сумдад жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор "Үйлдвэр хөгжүүлэх сан" байгуулах | Сум бүрт олгох санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ | 50.0 сая/ас доошгүй төгрөг | 16.8 Бусад эх үүсвэр | ХХААХҮЯ СЯ |
| 5.3 | ЗГҮАХ-ийн 2.3.8 дахь заалт | Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн эрх зүйн орчныг бүрдүүлж, байгуулах | Шинээр байгуулах түүхий эдийн биржийн тоо | 1 | 1.0 Улсын төсөв | ХХААХҮЯ |
| 5.4 | ЗГҮАХ-ийн 2.2.28, 2.3.1 дэх заалт "Хүнсний баталгаат байдал" хөтөлбөр | Мах, сүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх | Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээ<br><br>Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ | 30 мянган тонн<br><br>25 мянган тонн | 1.0 Улсын төсөв | ХХААХҮЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.5 | ЗГҮАХ-ийн 3.3 дахь заалт | Улаанбаатар хотод арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн технологийн хаягдал усыг цэвэрлэх байгууламжийн техник, технологийг шинэчлэх | Техник, технологийг шинэчлэх ажлын гүйцэтгэл, хувь | 50 | 4.0 Улсын төсөв | ХХААХҮЯ |
| **Зорилт-6. Бүсчилсэн хөгжлийг дэмжих, хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот, тосгоныг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 6.1 | ЗГҮАХ-ийн 2.4.2 дахь заалт | Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт | 50 хувь | 0.75 Улсын төсөв | ЗТБХБЯ |
| 6.2 | ЗГҮАХ-ийн 2.4.6 дахь заалт | GPS-ийн технологийг нэвтрүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрийг солбилцолын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж зурагжуулах | Шинээр байгуулах станцын тоо<br>Зурагжуулах газар нутгийн хэмжээ | 6<br>45 хувь | 1.4 Улсын төсөв | ЗТБХБЯ |
| 6.3 | ЗГҮАХ-ийн 2.2.26.1 дэх заалт | Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаар эрчимжүүлэх | Үйл ажиллагааг нь эрчимжүүлэх чөлөөт бүсийн тоо | 4 | 2.0 Улсын төсөв | Шадар сайдын ажлын алба |
| 6.4 | ЗГҮАХ-ийн 2.4.9, 2.4.36 дахь заалт | "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-г Улсын Их Хурлаар батлуулах, бүсийн тулгуур төв хотуудын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудыг түшиглэн хөгжих хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах | Тодотгол хийх төлөвлөгөөний тоо /Улаанбаатар хот/<br>Тодотгол хийх төлөвлөгөөний тоо /Бүсийн тулгуур төв/<br>Шинээр боловсруулах төлөвлөгөөний тоо | 1<br>3<br>2 | -<br>-<br>1.56 Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЗТБХБЯ,<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид "НЗДТГ" гэх/ |
| 6.5 | | Хүн амын төвлөрлийг сааруулах, төвлөрлөөс үүдэлтэй сөрөг үзэгдэл, газар эвдрэлт зэрэг байгалийн гамшгийн эрсдэл болон экологийн хохирлыг багасгах | | | | ХХААХҮЯ, БОАЖЯ, ЗТБХБЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн түүхий эдийн боловсруулах үйлдвэр, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилгоор нийслэл хотын хэт төвлөрлийг бууруулж эдийн засгийн идэвхжилттэй бусийг тэлж өргөжүүлэх, улмаар дунд хугацаанд энэ бусэд зорчигч тээврийн цахилгаан хурдан галт тэрэг явуулах нөхцөл, эдийн засгийн боломжийн талаар судалгаа хийж, бэлтгэл ажлыг эхлүүлэх шийдвэрийг гаргуулах | | | | |
| 6.6 | ЗГҮАХ-ийн 2.2.11 дэх заалт | Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил, иж бүрдэл зураг, геохимийн зураглал зохиох, хилийн дагуух болон эдийн засгийн бүс, зарим хүдрийн дүүрэгт судалгааны ажил гүйцэтгэх, үндэсний геомэдээллийн сан бүрдүүлэх | Геологийн 1:50000, 1:200000, 1:1 000000-ны зураглал, зураглийн ажлын гүйцэтгэл, хувь | 100 | 2.0 Улсын төсөв | ЭБЭХЯ |
| 6.7 | | Засгийн газрын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор баталсан "Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх | | | | ЗГХЭГ,СЯ, ЗТБХБЯ |
| **Зорилт-7: Хүн амын ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ.** | | | | | | |
| 7.1 | ЗГҮАХ-ийн 2.4.15, 2.4.23 дахь заалт "Транзит Монгол" үндэсний хөтөлбөр" 3.5, 4.2 дахь заалт | Улаанбаатар хот, Замын-Үүд суманд зорчигч тээврийн авто вокзал барих ажлыг эхлүүлэх | Барилгын ажлын явц /Улаанбаатар хот/<br>Барилгын ажлын явц /Замын-Үүд сум/ | 30 хувь<br>20 хувь | 0.27 Улсын төсөв, ТХХТ-ийн хөрөнгөөр | ЗТБХБЯ |
| 7.2 | ЗГҮАХ-ийн 2.2.24, 2.4.12 дахь заалт | "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах, эхний үе шатанд баригдах төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийг | Төмөр замын аж ахуйг сайжруулах төслийн тоо<br>Шинээр барих төмөр | 1 | 5.7 Гадаад эх үүсвэр<br>1120.0 Төр, хувийн | ЗТБХБЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | бологсруулж, замын барилгын ажлыг эхлүүлэх | замын урт. /Таван толгой-Сайншанд-Чойбалсан/ | 400 хүртэл км | хэвшлийн түншлэл, гадаад эх үүсвэр | |
| 7.3 | ЗГҮАХ-ийн 2.4.18 дахь заалт | Чойр-Замын-Үүд чиглэлийн авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэх | Барилгын ажлын явц | 70 хувь | 0.235 Улсын төсөв, 17.0 Гадаад эх үүсвэр | ЗТБХБЯ |
| 7.4 | ЗГҮАХ-ийн 2.4.9 дэх заалт | Улаанбаатар хотын авто замын сүлжээг шинэчлэн сайжруулах | Шинэчлэн сайжруулах авто замын урт | 50 км | 15.0 Улсын төсөв | ЗТБХБЯ, НЗДТГ |
| 7.5 | ЗГҮАХ-ийн 2.4.18 дахь заалт | Баруун босоо тэнхлэгийн авто зам барих ажлыг үргэлжлүүлэх | Ярант-Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн авто зам барих ажлын явц | 586 км авто замын барилгын ажил гүйцэтгэж, 40 км авто зам ашиглалтад орно | 6.0 Улсын төсөв, 32.3 Азийн хөгжлийн банк, 26.0 БНХАУ-ын зээл | ЗТБХБЯ |
| 7.6 | ЗГҮАХ-ийн 2.4.17 дахь заалт | "Мянганы зам" төслийн хэвтээ тэнхлэгийн авто зам барих ажлыг үргэлжлүүлэх | Халзанбүргэдэй-Солонготын давааны чиглэлийн ашиглалтад орох авто замын урт<br>Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн ашиглалтад орох авто замын урт | 100 км<br>50 км | 14.0 Улсын төсөв<br>5.4 Улсын төсөв | ЗТБХБЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7.7 | ЭГҮАХ-ийн 2.4.18 2.4.17, 2.5.5 дахь заалт | Аймгийн төвүүдийг нийслэл хоттой авто замаар холбох | Архангай, Хөвсгөл, Баянхонгор аймгийн төвийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбох. Алтай, Мандалговь, Даланзадгадын авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 180 км авто зам ашиглалтад орно | 25.0 Улсын төсөв, 15.4 Кувейтийн сан, 12.4 бусад эх үүсвэр | ЗТБХБЯ |
| 7.8 | ЭГҮАХ-ийн 2.4.10 дахь заалт | Төв аймгийн Хөшигийн хөндийд олон улсын нисэх буудлын дэд бүтэц барих ажлыг үргэлжлүүлэх | 110 кВт-ын цахилгаан дамжуулах шугам татаж, дэд станцыг байгуулах<br>Төв аймгийн Зуунмод хотоос шилэн кабель татаж, дамжуулах төхөөрөмжийг байгуулах<br>Улаанбаатар-Хөшигийн хөндий чиглэлийн хатуу хучилттай авто замыг барих ажил | 10 хувь<br>100 хувь<br>10 хувь | 2.7 Улсын төсөв | ЗТБХБЯ, ЭБЭХЯ, СЯ |
| 7.9 | ЭГҮАХ-ийн 2.2.7.5 дахь заалт, ҮХЦБ-ын 5.3.2.2 дахь заалт | Нийслэл, аймаг, орон нутгийн инженерийн дэд бүтцийг сайжруулах | Жижиг трансформаторын дэд станц баригдах сумын тоо | 9 | 3.2 Азийн хөгжлийн банк | ЭБЭХЯ |
| | | | Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламж, шугам сүлжээг шинэчлэх хувь | 33 | 2.5 Улсын төсөв | ЗТБХБЯ, НЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Цэвэр, бохир усны шугам сүлжээг шинэчлэх аймгийн тоо | 5 | 4.0 Улсын төсөв | ЗТБХБЯ |
| 7.10 | ЗГҮАХ-ийн 2.2.17.8 дахь заалт | Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, уг нүүрсний уурхайг түшиглэсэн цахилгаан станц барих ажлыг эхлүүлэх | Шинээр боловсруулах техник, эдийн засгийн үндэслэлийн тоо | 1 | 0.5 Улсын төсөв, 0.5 гадаад эх үүсвэр | ЭБЭХЯ |
| 7.11 | ЗГҮАХ-ийн 2.4.28.1 дэх заалт | Хөвсгөл аймгийн Могойн голын нүүрсний уурхайг түшиглэсэн цахилгаан станц барих техник, эдийн засгийн үндэслэл, Тэлмэн-Могойн голын цахилгаан дамжуулах шугам, дэд станц барих ажлыг үргэлжлүүлэх | Шинээр нэмэгдэх хүчин чадал | 60 мВт | 140.0 Төр, хувийн хэвшлийн түншлэл | ЭБЭХЯ |
| 7.12 | ЗГҮАХ-ийн 2.5.4.1 дэх заалт | Цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, засвар шинэчлэлийг үргэлжлүүлэх | Дулааны хүчин чадлыг нэмэгдүүлэх хэмжээ | 100 ГКал | 3.0 Улсын төсөв | ЭБЭХЯ |
| | | | Цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх хэмжээ | 60 мВт | 8.0 Улсын төсөв | ЭБЭХЯ |
| | | | Улаанбаатар хотын цахилгаан кабелийн сувгийн шинэчлэлт | 45 км | 6.0 Улсын төсөв | ЭБЭХЯ |
| 7.13 | ЗГҮАХ-ийн 2.4.29 дэх заалт | Сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Салхин парк барих ажлыг эхлүүлэх | Шинээр нэмэгдэх хүчин чадал | 50 мВт | Хувийн хөрөнгө оруулалт | ЭБЭХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7.14 | | Налайх-Зуунмод чиглэлд 28 км авто замыг улсын төсвийн хөрөнгөөр барих | | | | ЗТБХБЯ |
| 7.15 | | Аймаг, сумдын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулж, шинэчлэх | | | | ЭБЭХЯ |
| 7.16 | | Өмнөговь аймгийн Ханбогд-Оюу толгой чиглэлийн 35 кВт-ын 45 км цахилгаан дамжуулах шугам барих | | | | ЗТБХБЯ |
| 7.17 | | Өмнөговь аймгийн Ханбогд-Манлай сумын 15 кВт-ын 100 км цахилгаан дамжуулах шугам барих | | | | ЭБЭХЯ |
| 7.18 | | Улаанбаатар-Мандалговь-Даланзадгадын хатуу хучилттай авто замыг барьж дуусгах | | | | ЗТБХБЯ |
| 7.19 | | Завхан аймгийн Донойн нисэх онгоцны буудал хүртэлх 35 км сайжруулсан замыг хатуу хучилттай авто зам болгож өөрчлөх | | | | ЗТБХБЯ |
| 7.20 | | Архангай аймгийн Батцэнгэл сумын Тамирын гол дээгүүр төмөр бетон гүүр барих | | | | ЗТБХБЯ |
| 7.21 | | Улаанбаатар хотын оршин суугчдын аюулгүй байдлыг хангах, тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор нийслэл хотыг гадаргуугийн ба хөрсний уснаас хамгаалах барилга байгууламжийн иж бүрэн зураг төслийг бэлэн болгох | | | | ЗТБХБЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7.22 | | Архангай аймгийн Өгийнуур сумаас Хөвсгөл аймгийн Мөрөн хот хүртэл өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх дараа төлөгдөх нөхцөлөөр хатуу хучилттай авто зам барих | | | | ЗТБХБЯ |
| 7.23 | | Баруун чиглэлийн цахилгааны шугам сүлжээний алдагдлыг бууруулахын тулд Баянтээгийн нүүрсний уурхай дээр 20 мВт-ын цахилгаан станц байгуулах | | | | ЭБЭХЯ |
| **ГУРАВ. ХҮНД ЭЭЛТЭЙ БАЙГАЛЬ ОРЧИН, БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт-8. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгаралтыг багасгаж, хуримтлагдсан байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулна.** | | | | | | |
| 8.1 | ЗГҮАХ-ийн 3.1 дэх заалт, ҮХЦБ-ын 6.6 дахь заалт, НҮБ-ын Суурь Конвенц, Киотогийн протокол | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бий болгож бэхжүүлэх | Хэрэгжүүлэх ногоон эдийн засгийн төслийн тоо | 4 | 0.5 Улсын төсөв | БОАЖЯ, ХХААХҮЯ |
| 8.2 | ЗГҮАХ-ийн 3.16, ҮХЦБ-ын 6.2 дахь заалт | Амьтан, ургамлын тархац нөөцийн судалгаанд үндэслэн амьдрах орчинд нь хамгаалах, өсгөн үржүүлэх зохистой менежментийг хэрэгжүүлэх | Шинээр боловсруулах хөтөлбөрийн тоо | 1 | 0.015 Улсын төсөв | БОАЖЯ |
| 8.3 | ЗГҮАХ-ийн 3.3, 3.5 дахь заалт,<br>ҮХЦБ-ын 6.3 дахь заалт,<br>"Ус" үндэсний хөтөлбөр | Газрын доорх усны хяналт, шинжилгээг өргөжүүлэн, аюулгүй бохир ус цэвэрлэх техник, технологийн зохистой шийдлийг тодорхойлох | Гидрогеологийн судалгаа хийх газрын тоо<br>Шинээр байгуулах усны цооногийн тоо<br>Усыг эргүүлэн ашиглах шинэ технологи гаргах | 4<br>150<br>1 | 0.7 Улсын төсөв,<br>0.2 Төр хувийн хэвшлийн түншлэл | БОАЖЯ |
| 8.4 | ҮХЦБ-ын 6.3 дахь заалт | Хөв, цөөрөм байгуулж, хур бороо, гадаргын түр урсацыг хуримтлуулах | Шинээр байгуулах хөв, цөөрмийн тоо | 8 | 1.0 Улсын төсөв | БОАЖЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8.5 | ЗГҮАХ-ийн 3.6 дахь заалт, "Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.3 дахь заалт | Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг өргөтгөх | Шинээр байгуулах экспедицийн тоо<br><br>Генератор суурилуулах газрын тоо | 9<br><br>7 | 0.5 Улсын төсөв | БОАЖЯ |
| **Зорилт-9. Байгаль орчинд халгүй цэвэр технологийг дэмжиж, аялал жуулчлалыг хөгжүүлэн, байгаль орчны доройтлыг нөхөн сэргээх ажлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 9.1 | ЗГҮАХ-ийн 2.4.9, 2.4.35 дахь заалт | "Шинэ бүтээн байгуулалт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд: | Агаарын бохирдлыг бууруулах хувь | 10 | - | БОАЖЯ, ЗТБХБЯ,<br><br>НЗДТГ, ЭБЭХЯ |
| | | -хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд байгалийн шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг автотээврийн хэрэгсэл ашиглах | Шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг болгож тоноглосон том болон дунд оврын нийтийн тээврийн хэрэгслийн тоо | 800 | 3.5 Төр, хувийн хэвшлийн түншлэл | |
| | | -"Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх | Шинээр барих түрээсийн орон сууцны тоо<br>7, 14 дүгээр хороолол, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн орчмын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээг барих ажлын явц | 500 айлын орон сууц<br><br>60 хувь | 15.0 Төр, хувийн хэвшлийн түншлэл<br><br>18.0 БНХАУ-ын зээл | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | -Эрчим хүчний хэмнэлттэй байгальд халгүй хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх | Хийн түлш хэрэглэгч өрхийн тоо | 10 000 | Хувийн хөрөнгө оруулал-таар | |
| | | -Цахилгаан тээврийн хэрэгсэл дугуйг угсарч, парк шинэчлэлт хийх | Шинээр угсрах дугуйн тоо | 20 | 2.0 Улсын төсөв | |
| 9.2 | ҮХЦБ-ын 5.2.1.5 дахь заалт, Стратеги зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.18 дахь заалт | "Хархорум-13 зуун" Хархорин хотыг аялал жуулчлалын хот болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах | Шинээр боловсруулах техник, эдийн засгийн үндэслэлийн тоо | 1 | 0.8 Улсын төсөв | БОАЖЯ |
| 9.3 | ҮХЦБ-ын 6.4 дэх заалт, ЗГҮАХ-ийн 3.15 дахь заалт | Ойг нөхөн сэргээх, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах | Нөхөн сэргээж, ойжуулалт хийх талбайн хэмжээ | 6 мянган га | | БОАЖЯ |
| | | | Ногоон зурвас байгуулах талбайн хэмжээ | 200 га | | |
| | | | Иргэд, байгууллагаас худалдан авах таримал ойн хэмжээ | 150 га | | |
| 9.4 | ҮХЦБ-ын 6.4 дэх заалт | Ойг хөнөөлт шавьж, өвчин, ой хээрийн түймрээс хамгаалах урьдчилан сэргийлэх тэмцэх ажлыг зохион байгуулах | Шавьж, өвчнөөс урьдчилан сэргийлэх талбайн хэмжээ | 118.8 мянган га | | БОАЖЯ |
| | | | Судалгаа хийх талбайн хэмжээ | 2 сая га | | |
| | | | Түймрээс хамгаалах зурвасын урт | 600 км | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 9.5 | ЗГҮАХ-ийн 3.19 дэх заалт | Уул уурхайн олборлолт, ашиглалтын явцад элэгдэл, эвдрэлд ертөнц газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх | Эвдрэлд ертөнц газрын техникийн нөхөн сэргээлт | 62 хувь | Тусгай сан бий болгох замаар | Шадар сайдын ажлын алба, БОАЖЯ, ЭБЭХЯ |
| 9.6 | ЗГҮАХ-ийн 3.14 дэх заалт | Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг бэхжүүлэх, ой, хээрийн түймэр болон байгалийн гамшгаас сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100 хувь | 0.9<br>Улсын төсөв | БОАЖЯ |
| 9.7 | | Цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад усны нөөцийг нэмэгдүүлэх, мод, бут, сөөг тарьж ургуулан ногоон хэрмийн хэмжээнд хүргэх ажлыг эрчимжүүлэх, цөлжилтөөс сэргийлэх, хөрс хамгаалах эрх зүйн орчныг бий болгох, цөлжилттэй тэмцэх сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх | | | | БОАЖЯ |
| **ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт-10. Бүх шатны боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 10.1 | ЗГҮАХ-ийн 1.2.25 дахь заалт | Хүүхдэд урлагаар дамжуулан гоо зүйн хүмүүжил олгох нөхцөлийг нэмэгдүүлэх | Шинээр байгуулах хүүхэлдэйн театрын тоо | 1 | 0.32<br>Улсын төсөв | БСШУЯ |
| 10.2 | | Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх | Шинээр барих цэцэрлэгийн тоо<br><br>Өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлэх цэцэрлэгийн тоо | 20<br><br>20 | 4.0<br>Улсын төсөв, Гадаад эх үүсвэр | БСШУЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10.3 | ҮХЦБ-ын зорилт 2 | Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий боловсролын хөтөлбөрийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх | Кембрижийн хөтөлбөрийг нэвтрүүлж эхлэх сургуулийн тоо | 2 | 1.5 Улсын төсөв | БСШУЯ |
| 10.4 | ЗГҮАХ-ийн 1.2.7 дахь заалт | "Үдийн цай" хөтөлбөрийг "Үдийн хоол" хөтөлбөр болгон өргөжүүлж, үг хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлэх | Үйл ажиллагаа нь тогтворжсон туршилтын сургуулийн тоо | 10 | 0.5 Улсын төсөв | БСШУЯ |
| 10.5 | ЗГҮАХ-ийн 1.2.8.3 дахь заалт | Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг зөөврийн компьютерээр хангах ажлыг эрчимжүүлэх | Зөөврийн компьютерээр хангах багшийн тоо | 2.5 мянган багш | 1.0 Улсын төсөв | БСШУЯ |
| 10.6 | ЗГҮАХ-ийн 1.2.9 дахь заалт | Ерөнхий боловсролын сургуулийн стандартын шаардлага хангахгүй болсон барилгыг шинэчлэх | Шинээр барих сургуулийн тоо | 5 | 2.5 Улсын төсөв | БСШУЯ |
| 10.7 | ЗГҮАХ-ийн 1.2.3.6 дахь заалт | Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг боловсролд тэгш хамруулах орчин, нөхцлийг сайжруулах | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах боломжийг бүрдүүлсэн ерөнхий боловсролын сургуулийн тоо | 20 | 0.4 Улсын төсөв | БСШУЯ |
| 10.8 | ЗГҮАХ-ийн 1.2.13 дахь заалт | Дээд боловсролын шинэчлэлийг эрчимжүүлэх, төрийн өмчийн их, дээд сургуулийн бүтцийн өөрчлөлтийг зохион байгуулж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр өгөөжийг дээшлүүлэх | Аттестатчилагдсан дээд боловсролын сургалтын байгууллагын тоо | 20 | 0.02 Улсын төсөв | БСШУЯ |
| | | | Дэлхийн топ 100 сургуулиас урих багшийн тоо | 200 | 2.8 Азийн хөгжлийн банк | |
| 10.9 | "Боловсрол" үндэсний хөтөлбөрийн стратегийн зорилт 4 | Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах | Эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна | 100 хувь | - | БСШУЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10.10 | ЗГҮАХ-ийн 1.3.8 дахь заалт | Мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүдийг бэхжүүлэх | Сургалтад хамрагдах багшийн тоо<br>Сургалтын болон дадлагын тоног төхөөрөмжийг шинэчлэх мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тоо | 1000<br>10 | 14.0<br>Монголын Мянганы сорилын сан | БСШУЯ |
| 10.11 | ЗГҮАХ-ийн 1.2.27.2 дахь заалт | Соёл, урлагийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх | Шинэ ном, хэвлэлээр хангагдсан орон нутгийн уншигчдын тоо /давхардсан тоогоор/ | 300.000 | 0.32<br>Улсын төсөв | БСШУЯ |
| 10.12 | | Орон нутгаасаа 500 км-ээс дээш алслагдсан сургуульд суралцаж байгаа оюутны ирэх, очих зардлыг тэр жилд нэг удаа хариуцах | | | | БСШУЯ, СЯ |
| 10.13 | | Хүн амын дотоодын шилжилт хөдөлгөөнийг бодлогоор зохицуулж, хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгах, иргэдийг орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс алслагдсан болон говийн бүсийн хүн ам, аж ахуй нэгж, байгууллагуудад тодорхой хэмжээний хөнгөлөлт, урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх | | | | НХХЯ, СЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт-11. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хүн амд ээлтэй, тэгш, хүртээмжтэй, чанартай эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүргэж, хүн амын өвчлөлийг бууруулна.** | | | | | | |
| 11.1 | ЗГҮАХ-ийн 1.1.4 дэх заалт | Төлбөрийн чадваргүй, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдэд үнэ төлбөргүйгээр төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн тусламжийг авах эрхийн бичиг олгох | Эрхийн бичиг олголт | 10 хувиас багагүй | 0.1 Азийн хөгжлийн банк, Япон Улс | Эрүүл мэндийн яам /цаашид "ЭМЯ" гэх/, НХХЯ |
| 11.2 | ЗГҮАХ-ийн 1.1.5 дахь заалт | Эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх | Нийт эмнэлгийн оронд хувийн эмнэлгийн орны эзлэх хувь | 15 хувиас багагүй | 0.115 Азийн хөгжлийн банк | ЭМЯ |
| 11.3 | ЗГҮАХ-ийн 1.1.14 дэх заалт | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь | 20 хувиас багагүй | 0.5 Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк | ЭМЯ, НХХЯ |
| 11.4 | ЗГҮАХ-ийн 1.1.13 дахь заалт | Жирэмсэн эмэгтэйчүүд болон хүүхэд, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах | Эхийн эндэгдэл, промилл /100.000 амьд төрөлтөд/<br><br>Нялхсын эндэгдэл, промилл /1000 амьд төрөлтөд/ | 60-аас ихгүй промилл<br><br>17-оос ихгүй промилл | 15.0 Улсын төсөв<br><br>1.5 Азийн хөгжлийн банк | ЭМЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Улаанбаатар хотод баригдах 4 дүгээр төрөхийн барилгын ажлын явц | 80 хувиас доошгүй | | |
| 11.5 | ЗГҮАХ-ийн 1.1.12, 1.1.7 дахь заалт | Сум, өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах | II, III шатлалын эмнэлэгт сум, өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжиж ирсэн үйлчлүүлэгчдийн хувь<br><br>Явуулын тусламж, үйлчилгээнд хамрагдах малчдын хувь | 70 хувиас багагүй<br><br>20 хувиас багагүй | -<br>1.0<br>Монголын Мянганы сорилын сан, Азийн хөгжлийн банк | ЭМЯ |
| 11.6 | ЗГҮАХ-ийн 1.1.19 дэх заалт | Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлэх, иргэдийн эрүүл аж төрөх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, иргэдийг дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх | Нийтийн биеийн тамир, спортын байгууллагаар үйлчлүүлэгчдийн тооны өсөлт | 5 хувиас багагүй | 1.0<br>Улсын төсөв<br>1.5<br>Гадаад эх үүсвэр | ЭМЯ |
| 11.7 | ЗГҮАХ-ийн 1.1.9, 1.1.20 дахь заалт | Халдварт өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх | Халдварт өвчний өвчлөл, промилл /10000 хүнд /<br><br>БЗДХ-ын тархалт, промилл, /10000 хүнд/<br><br>ХДХВ-ийн халдвар, промилл /10000 хүнд/ | 140-өөс ихгүй промилл<br><br>60-аас ихгүй промилл<br><br>0.05-аас ихгүй промилл | 25.0<br>Гадаад эх үүсвэр | ЭМЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11.8 | ЗГҮАХ-ийн 1.1.11, 1.1.22 дахь заалт | Оношлогоо-эмчилгээний төвүүдийг бэхжүүлэх, оношлогоо, эмчилгээний стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох | Оношлогооны үндэсний төвийн барилгын ажлын гүйцэтгэл<br>Алсын зайн оношлогоо, эмчилгээг ашигласан байгууллагын тоо | 20 хувь<br><br>10-аас доошгүй | 2.5<br>Улсын төсөв<br><br>30.0<br>Гадаад эх үүсвэр | ЭМЯ |
| 11.9 | ЗГҮАХ-ийн 1.1.6.8 дахь заалт | Төрийн өндөр болон тусгай албан хаагчдын эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээг нэгдмэл болгох замаар үйлчилгээний чадавхи болон аюулгүй байдлыг сайжруулах, энэ зорилгоор цэргийн эмнэлгийг өргөтгөн шинэчилсэн зохион байгуулалтад оруулах | Ажлыг эхлүүлэх хувь | 10 | 1.0<br>Улсын төсөв | Хууль зүй, дотоод хэргийн яам /цаашид "ХЗДХЯ" гэх/ |
| 11.10 | | Говийн бүс болон Орхон аймагт орчин үеийн эмчилгээ, оношлогооны төв байгуулах | | | | ЭМЯ |
| 11.11 | | Малчид, алслагдсан орон нутгийн иргэдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, өрхийн эмнэлгийн үйлчилгээг хөгжүүлэх | | | | ЭМЯ |
| 11.12 | | Иргэн бүрийг жилд нэг удаа эмнэлгийн иж бүрэн, нарийн мэргэжлийн цогц үзлэг оношлогоонд хамруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх | | | | ЭМЯ |
| 11.13 | | Улаанбаатар хотод телемедицины төв байгуулах | | | | ЭМЯ |
| 11.14 | | Эрүүл мэндийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, | | | | ЭМЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төрийн оролцоог багасгаж хувийн хэвшлийн эмнэлгийн оролцоог дэмжих, эрүүл мэндийн даатгалын сант нийгмийн даатгалын сангаас тусгаарлах, уг салбарт хувийн хэвшлийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, даатгалд хамрагдсан иргэдийн эм, эмчилгээ, оношлогоо, үйлчилгээний төлбөрийн эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх хэмжээг эмнэлгийн өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 50 хувьд хүргэх зорилтыг хэрэгжүүлэх, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох | | | | |
| 11.15 | | Зам, барилга, уул уурхай, үйлдвэр барих зэрэг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төслүүд дээр монгол ажилчдыг ажиллуулах зорилгоор мэргэжлийн сургалтын салбарт Азийн орнуудын мэргэжлийн сургалтын тогтолцоог нэвтрүүлэх, дутагдалтай мэргэжлээр ажилчдыг дотоодод бэлтгэх, хурдавчилсан сургалтаар мэргэжил эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах | | | | БСШУЯ, НХХЯ |
| **Зорилт-12. Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан, зорилтот бүлэгт чиглэсэн халамжийн шинэчлэлийн тогтолцоог төлөвшүүлэн бэхжүүлж, иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурлыг бууруулна.** | | | | | | |
| 12.1 | УХЦБ-ын 4.1.1 дэх заалт | Ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөрийг иргэдийн хэрэгцээ, чадавхид тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх | Ядуурлын түвшин, хувь | 32.8 хувиас илүүгүй байлгана | - | ЗГХЭГ, НХХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12.2 | Хүний хөгжил сангийн тухай хууль | Монгол Улсын иргэн бүрт 1.5 сая төгрөгийн хишиг, хувь хүртээх ажлыг зохион байгуулах | Иргэн бүрт олгох бэлэн мөнгөний дундаж хэмжээ | 190 мянган төгрөг | 513.0 Уул уурхайн орлого | СЯ, НХХЯ |
| | | | Төлбөрийн эрхэд хамрагдах иргэдийн тоо | 2.7 сая хүн | Уул уурхайн орлого | СЯ, НХХЯ, ЗГХЭГ, ЗТБХБЯ, БСШУЯ, ЭМЯ |
| 12.3 | ЗГҮАХ-ийн 1.4.1, 1.4.2 дахь заалт | Нийгмийн халамжийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхлэх | Халамжийн үйлчилгээний давхардлыг арилгаж, зорилтот бүлэгт чиглэсэн байх | Зорилтот бүлэгт чиглэсэн байна | - | НХХЯ |
| 12.4 | | Тэтгэврийн даатгалын сангийн менежментийг боловсронгуй болгож, эрх зүйн орчныг бүрдүүлэх | | | | НХХЯ |
| 12.5 | | Халамжийн үйлчилгээний зохион байгуулалт, менежментийг сайжруулж эмзэг бүлгийн хийгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрөөс олгож байгаа халамж үйлчилгээний үр дүнг дээшлүүлэх, энэ үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох ажлыг эхлэх | | | | НХХЯ |
| **Зорилт-13. Нийгмийн түншлэлийг төлөвшүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг баримталж, ажилгүйдлийг бууруулна.** | | | | | | |
| 13.1 | ҮХЦБ-ын 4.8.2 дахь заалт<br>ЗГҮАХ-ийн 1.3.12 дахь заалт | Хөдөлмөрийн зах зээлд хэрэгцээтэй байгаа мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх үйлдвэрлэл, сургалтын хөтөлбөрийг үргэлжлүүлэх, алслагдмал нутгийг шаардлагатай мэргэжилтнээр хангах, орон нутагт | Хөтөлбөрт хамрагдах иргэдийн тоо | 3.000 | 0.5 бусад эх үүсвэр | НХХЯ |
| | | | Ажлын байрны хангалтын хувь | 80 хувиас доошгүй | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | нь бэлтгэх, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | | | | |
| 13.2 | | Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг дэмжих арга хэмжээний хүрээнд шинээр ажлын байр бий болгох, ажлын байрыг өргөтгөхөд нь зориулж бичил зээл олгон хугацааг уртасгах, зээлийн барьцааны сан бий болгох, иргэдийн орлогыг нь барьцаалж зээл олгох хэлбэрийг нэвтрүүлэх эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх | | | | |
| 13.3 | | Хөдөлмөрийн чадвартай ажилгүй байгаа иргэдийн судалгааг хот, дүүрэг, аймаг, сум, баг, хороо бүрээр тодорхой гаргаж тэднийг ажлын байраар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх | | | | НХХЯ |
| 13.4 | | Шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчдыг эдийн засгийн аргаар дэмжих чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах | | | | НХХЯ |
| 13.5 | УХЦБ-ын 4.8.2, 4.8.3 дахь заалт<br><br>ЗГҮАХ-ийн 1.3.12 дахь заалт | Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд жижиг зээл олгох, сургалт, мэргэжлийн зөвлөгөө өгөх, бизнес инкубацийн үйлчилгээгээр дэмжих | Жижиг зээл олгох үйлчилгээнд хамрагдах албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо | 2 000 | 0.5<br>бусад эх үүсвэр | НХХЯ |
| | | | Сургалтад хамрагдах албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо | 8 000 | | |
| | | | Бизнес инкубацид хамрагдах албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо | 200 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ТАВ. ИРГЭНД ОЙРХОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ** | | | | | | |
| **Зорилт-14. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн үндсэн сүлжээ, дэд бүтцийг сайжруулах, шинэ техник, технологийг нэвтрүүлнэ.** | | | | | | |
| 14.1 | | "Сансрын холбооны үндэсний хиймэл дагуул" төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх | Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын явц | 100 хувь | 0.2 Улсын төсөв 1.0 Гадаад зээл | ЗГХЭГ |
| 14.2 | ЗГҮАХ-ийн 2.4.26 дахь заалт | Монгол Улсын радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг аналоги системээс тоон системд үе шаттайгаар шилжүүлэх | Нийт аймаг, сумдын телевизийн нэвтрүүлэг тоон системд шилжих хувь<br>Нийт аймаг, сумдын радиогийн нэвтрүүлэг тоон системд шилжих хувь | 50-аас доошгүй хувь<br>50 хүртэл | 2.0 Улсын төсөв<br>18.4 Гадаад зээл | ЗГХЭГ |
| 14.3 | ЗГҮАХ-ийн 2.4.25 дахь заалт | Сумдад интернэт протоколд суурилсан өгөгдөл дамжуулах, түгээх сүлжээ байгуулах | Сүлжээнд холбогдох сумын тоо | 35 | 1.5 Улсын төсөв | ЗГХЭГ |
| 14.4 | ЗГҮАХ-ийн 1.3.20 дахь заалт | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт гадаад болон дотоод аутсорсингийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх | Шинээр бий болох мэргэжилтэй боловсон хүчний тоо | 600 хүн | 0.6 бусад эх үүсвэр | ЗГХЭГ, БСШУЯ |
| 14.5 | ЗГҮАХ-ийн 4.4.3 дахь заалт | Иргэний шинэчилсэн бүртгэлийн тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлэх | Иргэний бүртгэлийн цахим архивын баримт бичгийн тоо<br>Иргэний ухаалаг үнэмлэх олгох бэлтгэл ажлыг хангах | 6 сая баримт бичиг<br>50 хувь | 2.0 Улсын төсөв | Тэргүүн Шадар сайдын ажлын алба |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 14.6 | | Иргэний биеийн өгөгдөл болон бусад төрлийн мэдээллийг агуулсан "Иргэний ухаалаг үнэмлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Энэ хөтөлбөрийн хүрээнд иргэний нийгмийн хамгааллын дугаар бий болгох асуудлыг шийдвэрлэх. "Иргэний бүртгэл-паспорт хяналтын нэгдсэн сүлжээ" төслийн хүрээнд хилийн боомтуудын сүлжээнд холбох арга хэмжээ авах | | | | Тэргүүн Шадар сайдын ажлын алба |
| Зорилт -15. Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн төлөв байдлыг судлан тодорхойлж, хийдэл, давхардал, зөрчлийг арилгах замаар хуулийг боловсронгуй болгоно. | | | | | | |
| 15.1 | ЗГҮАХ-ийн 4.1.1.1 дэх заалт | Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид эрх зүйн болон мэргэжлийн үүднээс төлөв байдлын шинжилгээ хийх ажлыг үргэлжлүүлэх | Эрх зүйн болон төлөв байдлын шинжилгээ хийгдсэн байх хууль тогтоомжийн хувь | 50 | Гадаад зээл үүсвэр | ХЗДХЯ, холбогдох яамд |
| 15.2 | ЗГҮАХ-ийн 4.1.6 дахь заалт | Хууль зүй, дотоод хэргийн салбарын бүсийн давтан сургалтын төвүүдийг байгуулж, сургалтын тогтолцоог бий болгох | Шинээр байгуулах сургалтын төвийн тоо | 5 | 0.2 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 15.3 | | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Улсын Их Хурлаар хэлэлцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх | | | | ЗГХЭГ, ХЗДХЯ |
| 15.4 | | Улсын Их Хурлаас 2002 онд баталсан "Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтэд мониторинг хийх | | | | ХЗДХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт-16. Хууль сахиулах болон хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах, архив, төрийн албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлнэ.** | | | | | | |
| 16.1 | ЗГҮАХ-ийн 4.1.3, 4.2.8 дахь заалт | Батлагдсан хууль тогтоомжийг төв, орон нутагт цаг алдалгүй хүргэх, эрх зүйн албан бус сургалтын хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт | 100 хувь | 0.3<br>бусад эх үүсвэр | ХЗДХЯ |
| 16.2 | ЗГҮАХ-ийн 4.2.7.1. 4.2.3.1 дэх заалт | Цагдаа, дотоодын цэргийг нийтийн хэв журмыг хамгаалахад шаардагдах зориулалтын техник хэрэгслээр үе шаттайгаар хангаж, шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд дэмжих | Парк шинэчлэлтийн хувь<br><br>Тусгай хэрэгслийн хангалтын хувь<br><br>Холбооны техник хэрэгслийн хангалтын хувь | 10<br><br>3<br><br>4.8 | 3.4<br>Улсын төсөв | ХЗДХЯ |
| 16.3 | ЗГҮАХ-ийн 4.2.5.2 дахь заалт | Алслагдсан сум, суурин, нийслэлийн дүүрэг, хороодод цагдаагийн кобан, бичил хэсэг барьж байгуулах | Барьж байгуулах кобаны тоо | 40 | 6.0<br>Улсын төсөв | ХЗДХЯ |
| 16.4 | ЗГҮАХ-ийн 4.2.6.1, 4.2.6.3, 4.2.6.4 дэх заалт | Гэмт хэргийн ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийхэд дэвшилтэт технологи бүхий лабораторийн техник, арга хэрэгслийг ашиглан хараат бус, шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн зөв дүгнэлт гаргах нөхцөлийг бүрдүүлэх | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр шинэчлэн тоноглох лабораторийн тоо<br><br>Нэгдсэн сүлжээнд холбох албадын тоо | 1<br><br>22 | 1.4<br>Улсын төсөв | ХЗДХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16.5 | ЗГҮАХ-ийн 4.3.3.1, 4.3.3.2 дахь заалт | Улсын хилийг хамгаалах үүргийг "мэргэшсэн гэрээт хилчин"-ээр гүйцэтгүүлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжих | Гэрээт хилчний албанд шилжих заставын тоо | 25 | 5.0 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 16.6 | ЗГҮАХ-ийн 4.3.4.1, 4.3.4.3, 4.3.4.4, 4.3.6 дахь заалт | Хил хамгаалах байгууллагын холбоо мэдээллийн тогтолцоо, техник хангамж, зэвсэглэлийг шинэчлэх, инженерийн техник хангамжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авах | Радио холбооны хэрэгслийн хангалтын түвшин, хувь | 97.3 | 3.0 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 16.7 | ЗГҮАХ-ийн 4.4.4.3 дахь заалт | Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх байгууллагын ажил, үйлчилгээг олон улсын жишигт ойртуулах, гадаадын иргэдэд тавих хяналтыг боловсронгуй болгох | Нэгдсэн сүлжээнд холбох нисэх буудлын тоо | 4 | 0.5 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 16.8 | ЗГҮАХ-ийн 4.2.11, 4.2.12.3, 4.2.13.2 дахь заалт | Хорих анги болон цагдан хорих байрны харуул хамгаалалтыг орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 80 | 4.0 Улсын төсөв, дотоод эх үүсвэр | ХЗДХЯ |
| 16.9 | ЗГҮАХ-ийн 4.1.8.1 дахь заалт | Үндэсний архивын шинэ цогцолбор барилгыг барьж байгуулах ажлыг үргэлжлүүлэх | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 76 | 4.0 Улсын төсөв | ХЗДХЯ |
| 16.10 | | Хүний эрх, эрх чөлөөг хангах, иргэдийн нэр төр, өмч хөрөнгө, орон байрны халдашгүй байдалтай холбогдсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шүүн таслах ажиллагааны хугацааг боломжит хэмжээнд богиносгох, хуулийн байгууллагын хараат бусаар ажиллах эдийн засаг, | | | | ХЗДХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зохион байгуулалтын орчныг бүрдүүлэх замаар хуулийн байгууллагын шинэчлэлийг гүнзгийрүүлэх | | | | |
| 16.11 | | Дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүднээс цагдаа, шүүхийн байгууллагыг камержуулах ажлыг эхлүүлэх | | | | ХЗДХЯ |
| **Зорилт 17. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэдэд хүргэж, үр дүнг сайжруулна.** | | | | | | |
| 17.1 | ЗГҮАХ-ийн 4.5.5 дахь заалт | Төрийн албан хаагчийн ёс зүйн сахилгыг дээшлүүлэх зорилгоор энэ чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлах | Дүрэм батлагдсан байна | - | ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар |
| 17.2 | ҮХЦБ-ын 5.1.7.2.1 дахь заалт | Зарим яам, агентлагийн олгодог тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үйлчилгээг "Нэг цонхны үйлчилгээ", "Бизнес ширээ"-ний үйлчилгээнд шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан Засгийн газраар батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах | Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх яамны тоо<br><br>Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх агентлагын тоо | 2<br><br>3 | 0.3<br>Улсын төсөв,<br><br>Гадаад эх үүсвэр | ЗГХЭГ |
| 17.3 | ҮХЦБ-ын 5.1.7.1 дахь заалт | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны стратегийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | 20 хүртэл | - | ЗГХЭГ |
| 17.4 | | Хяналт шалгалтын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, мэргэжлийн | Төрийн бус байгууллага, мэргэжлийн | 6-аас доошгүй | - | Шадар сайдын ажлын алба |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | холбоодын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх | холбоодоор гүйцэтгүүлэх хяналтын дэд чиглэлийн тоо | | | |
| 17.5 | ЗГҮАХ-ийн 2.1.15.2 дахь заалт | Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, цахим тайлангийн системийг өргөжүүлэх | Цахим тайлангийн гүйцэтгэл, хувь | 80 | - | СЯ |
| 17.6 | ЗГҮАХ-ийн 2.1.15.2 дахь заалт | Гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлж, үйл ажиллагаар бүрэн цогц автоматжуулах, цаасгүй бүрдүүлэлтэд шилжих | Цаасгүй гаалийн бүрдүүлэлт, хувь | 50 | - | СЯ |
| 17.7 | | Яам агентлаг, нутгийн захиргааны байгууллагыг хамарсан чиг үүргийн шинжилгээг үргэлжлүүлэн хийх | Яам, агентлаг, байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийх | Чиг үүргийн шинжилгээ хийгдсэн байна | Гадаад эх үүсвэр | ЗГХЭГ |
| 17.8 | ЗГҮАХ-ийн 1.5.12, ҮХЦБ-ын 4.2.1 дэх заалт | Бүх салбарт жендэрийн тэгш байдлыг хангах, жендэрийн статистик мэдээллийг гаргах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 0.01<br>Улсын төсөв | Бүх яамд, ЖТБҮХ, ҮСГ |
| **ЗУРГАА. ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ** | | | | | | |
| **Зорилт-18. Олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж, гадаад худалдааг эдийн засагжуулах бодлого баримтална.** | | | | | | |
| 18.1 | Гадаад бодлогын үзэл баримтлалын 12.1 дэх заалт, ЗГҮАХ-ийн 5.1.1.3 дахь заалт | Хоёр хөрштэй харилцан ашигтай, тэнцвэртэй харилцах бодлого баримталж, ОХУ-тай стратегийн түншлэлийн харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулж, БНХАУ-тай сайн хөршийн харилцан итгэсэн түншлэлийн харилцааг бэхжүүлэх | Шинээр боловсруулах дунд хугацааны хөтөлбөрийн тоо | 1 | 0.05<br>Улсын төсөв | ГХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 18.2 | Гадаад бодлогын үзэл баримтлалын 12.2 дахь заалт, ЗГҮАХ-ийн 5.1.1 дэх заалт | АНУ, Япон, Канад, Герман болон Европын Холбооны бусад оронтой иж бүрэн түншлэлийн түвшинд харилцах бодлого баримтлах, Энэтхэг, БНСУ, Турк, Австрали, АСЕАН-ны орнуудтай түншлэлийн болон худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 0.155 Улсын төсөв | ГХЯ |
| 18.3 | ЗГҮАХ-ийн 5.1.8 дахь заалт | Хилийн чанадад байгаа Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэд гадаадад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, тэдэнд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, чанартай болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт | Иргэдийн гадаадад зорчих нөхцөл хөнгөвч-лөгдсөн байна. | 0.35 бусад эх үүсвэр | ГХЯ |
| 18.4 | ЗГҮАХ-ийн 5.1.9 дэх заалт | Эх орноо гадаадад сурталчлан таниулах, Монголын тухай зөв ойлголтыг бэхжүүлэх | Монгол Улсыг хилийн чанадад сурталчлан таниулах арга хэмжээний тоо | 20 | 0.2 Улсын төсөв | ГХЯ |
| 18.5 | ЗГҮАХ-ийн 5.1.7 дахь заалт | Хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч байгаа өндөр боловсрол, нарийн мэргэжил эзэмшсэн Монгол Улсын иргэдийг эх | Шинээр бүртгэлд хамрагдах иргэдийн тоо | 20000 хүртэл | - | ЗГХЭГ, ГХЯ, НХХЯ, БСШУЯ, ЭМЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | орондоо ирж ажиллах эрх зүй, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Зөгийн үүр" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | | | | ХХААХҮЯ, ЭБЭХЯ |
| 18.6 | ЗГҮАХ-ийн 5.1 дэх заалт | Гол түнш орнуудаас үзүүлж байгаа худалдааны хөнгөлөлтийг өргөжүүлж, хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих бодлого хэрэгжүүлэх | Европын Холбооны хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP)-ийн ашиглалтын хувь | 100 | 0.1<br>Улсын төсөв | ГХЯ |
| 18.7 | ЗГҮАХ-ийн 5.1.4 дэх заалт | Далайд гарцгүй орны эрх ашгийг идэвхтэй хамгаалсан бодлогыг тууштай явуулж, ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэрээр монголын бараа, бүтээгдэхүүнийг дамжин өнгөрүүлэх таатай орчныг бүрдүүлэх | Энэ чиглэлээр хийх судалгааны тоо<br><br>2 хөрштэй дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрийг байгуулах ажлын явц | 1-2 судалгаа<br><br>70-аас доошгүй хувь | 0.1<br>Улсын төсөв | ГХЯ, ЗТБХБЯ |
| 18.8 | | Таван толгойн төсөлд гадаадын хөрөнгө оруулагчдыг оролцуулахад тавих уггвар нөхцөлийн хүрээнд тэдгээр улсын Засгийн газрын хэрэгцээний тодорхой бараа бүтээгдэхүүнийг Монгол Улсад үйлдвэрлэж нийлүүлэх талаар холбогдох улсын Засгийн газартай улс төрийн тохиролцоо хийж шийдвэрлэх | | | | ГХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-19. Батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэх, Зэвсэгт хүчний байгууламтыг төгөлдөржүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, Зэвсэгт хүчний олон талт үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 19.1 | ЗГҮАХ-ийн 5.2.5 дахь заалт | Цэрэг-стратегийн бэлтгэл сургалтын тогтолцоог боловсронгуй болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 0.085 Улсын төсөв | БХЯ |
| 19.2 | Зэвсэгт хүчний байгууламтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн 3.3.4.5 дахь заалт | Батлан хамгаалах салбарын шинжлэх ухаан, технологийн чадавхийг нэмэгдүүлж, судалгаа-сургалт-үйлдвэрлэлийн нэгдмэл тогтолцоог бий болгох | Судалгаа-сургалт-үйлдвэрлэлийн тогтолцоог бий болгох ажлын гүйцэтгэл, хувь | 100 | 0.1 Улсын төсөв | БХЯ |
| 19.3 | Зэвсэгт хүчнийг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр 3.1.9 дэх заалт | Зэвсэгт хүчний сургалтын нэгдсэн төвийг түшиглэн Энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургалтын төвийг байгуулах | Сургалтын төв байгуулах ажлын гүйцэтгэл, хувь | 100 | 1.5 Бусад эх үүсвэр | БХЯ |
| 19.4 | Зэвсэгт хүчний байгууламтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр | "Цэргийн орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд байгууллагын орон сууц барих | Шинээр барьж байгуулах орон сууцны тоо, айлаар | 213 айлын орон сууц | 1.6 Төр, хувийн хэвшлийн түншлэл | БХЯ |
| 19.5 | Зэвсэгт хүчнийг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр | НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон цэргийн албан хаагчдын сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх цогцолбор төв байгуулах | Шинээр байгуулах цогцолбор төвийн тоо | 1 | 5.4 БНХАУ-ын тусламж | БХЯ |
| 19.6 | Зэвсэгт хүчнийг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр | Улс орны бүтээн байгуулалтын ажил, арга хэмжээнд зэвсэгт хүчний бүрэлдэхүүн, техник хэрэгслээр дэмжлэг үзүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | - | БХЯ |
| 19.7 | ЗГҮАХ-ийн 5.2.8.2 дахь заалт | Цөлжилттэй тэмцэх аяныг зохион байгуулж, зэвсэгт хүчний анги салбарууд харьяаллын бүс нутагтаа цэцэрлэгт хүрээлэн байгуулах | Аяны хүрээнд байгуулах цэцэрлэгт хүрээлэнгийн тоо | 10 | 0.2 бусад орлого | БХЯ БОАЖЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19.8 | | Агаарын орон зайн хяналт, халхлалтын зэвсэглэл, техникийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх | | | | БХЯ |
| 19.9 | | Цэргийн болон иргэний нисэхийн бүх төрлийн агаарын хөлгийг хүлээн авах, тэдгээрт газрын, радиотехникийн болон навигацын үйлчилгээ үзүүлэх "Цэргийн нисэх буудал" төсөл Налайх дүүрэгт хэрэгжүүлэх | | | | БХЯ |
| 19.10 | | Зэвсэгт хүчний анги салбарт ашиглагдаж байгаа зэвсэг, галт хэрэгсэл, нөөцийн агуулах, бусад барилга байгууламжийг сэргээн засварлах "Барилгын засвар" төсөл хэрэгжүүлэх | | | | БХЯ |
| 19.11 | | Батлан хамгаалах нөөцийн удирдлага зохицуулалтыг сайжруулж, цэргийн дайчилгааны нөөцийг үе шаттайгаар сольж шинэчлэх "Дайчилгааны нөөц" төсөл хэрэгжүүлэх | | | | БХЯ |
| 19.12 | | Улс орны бүтээн байгуулалтад шаардлагатай мэргэжлийн боловсролыг олгох, барилга, хүнд механизмын мэргэжилтэн бэлтгэх | | | | БХЯ |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар сарын 09-ний өдөр — Дугаар 46 — Улаанбаатар хот

**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2010 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай" Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 99 дүгээр тогтоолын 2 дахь заалтын 4 дэх дэд заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4/Монгол Улсын иргэнд хүртээх хишиг, хувийн эхний ээлжийн 70.0 мянган /далан мянга/ төгрөгийг 2010 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож, үлдэх хөрөнгийг 2010 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр хуваан олгох, цаашид хишиг, хувийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх."

2.Энэ тогтоолыг 2010 оны 7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 07 дугаар сарын 09-ний өдөр — Дугаар 47 — Улаанбаатар хот

**Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдсаны 20 жилийн ойг тэмдэглэх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдсаны 20 жилийн ойг 2010 оны 10 дугаар сарын эхний хагаст тэмдэглэхээр тогтоосугай.

2. Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдсаны 20 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдсаны 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлах, хэрэгжүүлэхийг ажлын хэсэг /Г.Батхүү/-т үүрэг болгосугай.

4.Монгол Улсад байнгын ажиллагаатай Парламент байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээнд шаардагдах зардлыг Улсын Их Хурлын 2010 оны урсгал төсвийн зохих зардлаас гаргахыг Улсын Их Хурлын Тамгын газар /Ц.Шаравдорж/-т зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Д.ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2010 оны
47 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСАД БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТ БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

**Ажлын хэсгийн ахлагч:**

1.Г.Батхүү- Улсын Их Хурлын дэд дарга

**Нарийн бичгийн дарга:**

2.Ц.Шаравдорж -Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга

**Гишүүд:**

3. Н.Энхболд - Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга
4.Ө.Энхтүвшин - Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга
5.С.Баярцогт - Улсын Их Хурлын гишүүн
6.З.Алтай - Улсын Их Хурлын гишүүн
7.Су.Батболд - Улсын Их Хурлын гишүүн
8.Н.Ганбямба - Улсын Их Хурлын гишүүн
9.Р.Гончигдорж - Улсын Их Хурлын гишүүн
10.Д.Дондог - Улсын Их Хурлын гишүүн

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2010 оны 06 дугаар сарын 30-ны өдөр — Дугаар 03 — Улаанбаатар хот

**Банкны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, Ж.Амарсанаа, Д.Наранчимэг /илтгэгч/, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Г.Агар-Эрдэнийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Д.Ламжав, Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Балдан-Очир нар оролцов.

Хуралдаанаар Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 57 дугаар зүйлийн 57.1.2, 57.3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3/ дахь заалтыг, 36 дугаар зүйлийн 36.4, 36.11, 36.12 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3/ дахь заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэв.

**Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Ламжав 2010 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэлдээ:**

"...Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад "холбогдох этгээд" гэх хуулийн нэр томьёог а, б, в, г, д, е, ё, ж гэсэн найман дэд заалтаар тодорхойлжээ. Энэ нэр томьёо маш өргөн хүрээг хамаарснаас гадна, заримдаа таамаглан тогтоох, бүр сүүлдээ Монголбанкны үзэж байгаагаар энэ нэр томьёог хэрэглэхээр тодорхойлсон байна...

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт "холбогдох этгээд гэж дор дурдсан иргэн, хуулийн этгээдийг;" 3.1.2.а - 3.1.2.ж хүртэлх хэсэгт аливаа хуулийн этгээдийн хувьцаанд хамаарах үнэт цаасыг шууд болон шууд бус хэлбэрээр эзэмшиж байгаа болон уг хувьцааг гаргагч, ирээдүйд эзэмших, гаргах этгээд, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд, аливаа хуулийн этгээдийн бодлого, үйл ажиллагаанд хэлцлийн үндсэн дээр шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг, хяналт тавьдаг, түүнийг хүлээн зөвшөөрсөн этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд, тухайн хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн болон хянан шалгах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, тэдгээр нь шууд буюу шууд бус хэлбэрээр хяналтаа хэрэгжүүлдэг хуулийн этгээд, түүний нэгдмэл сонирхолтой этгээд болон эцэст нь Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн этгээдийг холбогдох этгээд байхаар маш өргөн хүрээнд хуульчилсан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчиж байна.

Банкны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Монголбанк, төрийн бусад байгууллага банкны үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд удирдлага, шийдвэрт нь хууль бусаар нөлөөлж болохгүй" хэмээн зохицуулсан боловч Монголбанк

холбогдох этгээдийг дур мэдэн тодорхойлохоор заасан нь угтаа банкны зээлийн үйл ажиллагаа, шийдвэрт Монголбанк оролцох боломжоор нээж, хуулийн заалтууд агуулгын хувьд зөрчилдөж, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн зарчим алдагдаж байна.

Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт "Банкнаас аливаа этгээд, түүнтэй холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь тухайн банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй", мөн зүйлийн 17.3 дахь хэсэгт "Банкнаас холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн таван хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас тус тус хэтэрч болохгүй..." хэмээн заасан байна. Холбогдох этгээд гэсэн нэр томьёог хуульд хэтэрхий өргөн агуулгаар томьёолж, үүний дээр Монголбанк хүртэл өөрийн үзэмжээр тодорхойлох эрхийг олгосны сацуу тэдгээрт банкнаас үзүүлэх санхүүгийн үйлчилгээнд хэтэрхий өргөн хүрээтэй хязгаарлалт тавьсан нь банкны бизнесийн хэвийн үйл ажиллагааг хязгаарлан хөрөнгийн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсад банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй 14 банк байдаг бөгөөд эдгээрээс зээл олгох хөрөнгө, чадвартай, дээр нь орон нутагт өөрийн салбартай банк цөөхөн байна. Иймд дээрх зохицуулалт нь бодит байдалд төдийлөн нийцэхгүйн дээр зарим иргэдийн банкны үйлчилгээ авах эрх хумигдаж, улмаар Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах..." эрх үндэслэлгүйгээр хязгаарлагдаж байна.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт "Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт Монголбанкны зөвшөөрөлгүйгээр нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон нь хяналт шалгалтаар тогтоогдсон, эсхүл энэ хуулийн 36.12-т заасныг зөрчсөн бол уг этгээдийн тухайн хувьцааны саналын болон ногдол ашиг авах эрхийг түдгэлзүүлж, хувьцааг сүүлд авсан дараалаар 30 хоногт багтаан хуульд заасан хязгаарлалтад хүрэх хэмжээнд албадан худалдахыг Монголбанк шаардах бөгөөд Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нэмж гарган худалдсан бол зөвшөөрөл аваагүй хувьцааны тоонд ногдох хэмжээг банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцно", 36.11 дэх хэсэгт "Энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан

банкны хувьцааг Монголбанк зөвшөөрснөөс бусад этгээдэд худалдахыг хориглоно", 36.12 дахь хэсэгт "Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно" гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 3-т "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй" гэснийг зөрчиж байна.

Өмчлөх эрх нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар "гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлагдах" боловч уг хязгаарлалтын үндэс нь мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй" гэсэн заалт хэмээн үзэж байна. Тодруулбал, хүний өмчлөх эрхийн хязгаарлалт нь бусдын эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал болон нийгмийн зайлшгүй шаардлага байх бөгөөд ийм шаардлагад тулгуурлаагүй хязгаарлалт бүхий хууль нь өөрөө өмчлөх эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн дээрх хэсэгт заасан банкны хувьцааг захиран зарцуулах, эзэмших эрхийг хязгаарласан, хориглосон заалтууд нь хүний өмчлөх эрхийг хязгаарлах үндэслэл болж чадахгүй байна.

Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Банк нь ... үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат ... байж болно" хэмээн заасан бөгөөд Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Нээлттэй буюу хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ" хэмээн заасан байна. Тодруулбал, нээлттэй компанийн хувьцаа нь хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалагдах боломжтой бөгөөд хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа харьат бусаар чөлөөтэй захиран зарцуулах, бусад этгээд түүнийг эзэмших эрхтэй байхыг нээлттэй компани гэж үздэг. Тиймээс 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.7, 36.11 дэх хэсэгт заасан зохицуулалтууд нь хувьцаат компанийн эрх зүйн зохицуулалтын үндэс болсон хувьцаа эзэмшигчийн чөлөөтэй захиран зарцуулах эрх болон бусад этгээдийн өмчлөх эрхийг ноцтой хязгаарлаж, тэдгээрийг ялгаварлан гадуурхаж, эрх зүйн байдлыг үндэслэлгүйгээр дордуулах, улмаар тэгш эрхийн зарчмыг зөрчихөөр байгаа нь мөн Компанийн тухай хуулийн зүйлтэй зөрчилдөж, хууль дээдлэх зарчим алдагдаж байна.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт нөлөө бүхий саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд бусад банкинд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглосон бөгөөд хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т "холбогдох этгээд"-ийн агуулгад хууль тогтоогч хэтэрхий өргөн хүрээтэй тайлбар өгсөн нь үнэн чанартаа огт холбоогүй этгээдийн өмчлөх эрхэд хүртэл хавтгайруулан халдах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн байна.

Аливаа этгээд, ялангуяа нээлттэй компанийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан чөлөөтэй захиран зарцуулах, түүнийг эзэмших (36.3, 36.4, 36.7, 36.11), мөн зүйлийн 36.12 дахь хэсэгт заасан банкны хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээдийн өөр банкинд нөлөө бүхий хувьцаа эзэмших зэрэг нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн явдал гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байгаа учир Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан өмчлөх эрхийг хязгаарлах хууль зүйн үндэслэлгүй байна.

Тус хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт "Банкны эрх хүлээн авах арга хэмжээг дор дурдсанаар хэрэгжүүлнэ" гээд 57.1.2 дахь хэсэгт "банкийг хуулийн этгээдийнх нь хувьд албадан татан буулгаж энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу банкны актив хөрөнгийг захиран зарцуулах.", мөн зүйлийн 57.3 дахь хэсэгт "Банкинд бүтцийн өөрчлөлт хийх тухай төлөвлөгөө батлах боломжгүй гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 57.2-т заасны дагуу Монголбанкны шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө амжилтгүй хэрэгжсэн тохиолдолд Монголбанк нь банкийг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана." хэмээн заасан нь Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт "Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана." гэсэнтэй зөрчилдөж байна. Тодруулбал, компанийг татан буулгах субъект нь хуульд зааснаар хувь нийлүүлэгчдийн хурал, шүүх гэж заасан байхад Банкны тухай хуулийн дээрх заалт, хэсэгт "...Монголбанк нь банкийг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана." хэмээн заажээ. Энэ нь улмаар Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэснийг зөрчжээ" гэжээ.

**Хоёр.Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Балдан-Очир 2010 оны 6 дугаар сарын 9-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:**

"Нэг. Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 28-ны

өдөр баталсан Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг тус тус зөрчин холбогдох этгээд гэсэн нэр томъёог хуульд хэт өргөн агуулгаар томьёолж, үүний дотор Монголбанк хүртэл өөрийн үзэмжээр тодорхойлох эрхийг олгосны сацуу тэдгээрт банкнаас үзүүлэх санхүүгийн үйлчилгээнд хэтэрхий өргөн хүрээтэй хязгаарлалт тавьсан нь банкны хэвийн үйл ажиллагааг хязгаарлан хөрөнгийн хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж байна гэж үзэж иргэн Д.Ламжав Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргажээ.

2010 оны 1 дүгээр сард баталсан Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 1974 онд Бельги, Канад, Герман, Итали, Япон, Голланд, Швед, Швейцар, Их Британи, Америк зэрэг 10 орнууд хамтран байгуулсан эдүгээ нийт 27 орны гишүүнчлэлтэй боловч тогтоосон зарчим, бусад стандартыг нь дэлхийн 100-аад орон сайн дурын үндсэн дээр нэгдэж, хэрэгжүүлэхээ албан ёсоор зарлаад байгаа олон улсын байгууллага болох Базелийн хорооноос 1997 оны 9 дүгээр сард батлаж 1999, 2006, 2007 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан "Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим"-д тулгуурлан боловсруулагдсан билээ.

Эдгээр Үндсэн зарчмууд нь банкны хяналт шалгалтыг зохистой хэрэгжүүлэхэд шаардлагатай, нийтлэг хэрэглэгдэх суурь хэм хэмжээнээс бүрддэг. Үндсэн зарчмуудыг дээр дурдсанчлан дэлхийн ихэнх орнууд хэрэгжүүлэхийг зорьдог бөгөөд дотоодын болон олон улсын санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулахаас гадна хяналт шалгалтын үр дүнг сайжруулах үндэслэл болно.

Тус зарчмын 11-д "Холбогдох этгээдийн эрсдэл: Холбогдох этгээдтэй холбоотой санхүүгийн үүргээс (тэнцэл дээр болон тэнцлийн гадуурхи) учирч болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилгоор хянан шалгагч нар банкнаас холбогдох этгээдэд зээл олгоход учирч болзошгүй эрсдлийг тогтоох, түүнээс сэргийлэх, учирсан алдагдлыг холбогдох хэм хэмжээний дагуу тэнцлээс хасах талаар тавигдах шаардлагуудыг тогтоох нь зүйтэй." гэж заасан байдаг.

Олон улсын туршлагаас харахад ихэнх улс орнууд холбогдох этгээдийн хүрээг Холдингийн тухай хууль зэрэг төрөлжсөн хуульдаа нарийвчлан тогтоосон байдаг бөгөөд ингэхдээ олон улсын нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартад заасан тодорхойлолтыг ашиглаж байна.

Монгол Улс нь Олон улсын аудитын болон нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг албан ёсоор мөрдөж эхлээд тодорхой хугацаа

өнгөрч байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх" шаардлага тавьдаг бол Аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт"Аудитын үйл ажиллагаанд аудитын олон улсын стандартыг мөрдөнө" гэж заасан байдаг.

Эдгээр стандарт тус бүрт "холбогдох этгээд" гэсэн ойлголтод тодорхойлолт өгсөн бөгөөд түүнд нийцүүлэн Банкны тухай хуульд "холбогдох этгээд"-ийн хүрээг тогтоосон билээ. Уг ойлголтыг байж болох бүхий л хүрээг хамарч тодорхойлох нь эдийн засгийн хувьд хянан шалгагч, аудиторуудад системийн эрсдэл, холбогдох этгээдийн гинжин холбоо, түүнээс үүдэн гарч болзошгүй эрсдлийг тогтоон илрүүлэх, түүнийг ойлгох нөхцлийг бүрдүүлдэг бол хууль зүйн үүднээс эрх зүйн зохицуулалтын аливаа хийдэл гаргахгүй байх боломж олгох юм.

Банкны тухай хуулийг бүхэлд нь авч үзвэл "холбогдох этгээд"-тэй холбоотой зохицуулалт үндсэн 2 бүлэг асуудлыг хамарч байгаа. Үүнд:

1. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйл буюу Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалттай холбоотой бүлэг харилцаа - уг зохицуулалтын хүрээнд нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгох зээл, баталгаа, батлан даалтын нийлбэр дүнд хязгаарлалт тогтооно.

2. Тус хуулийн 36 дугаар зүйл буюу банкны хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдтэй хамтран нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон үед тэдгээрийн хувьцаагаа захиран зарцуулах эрхийг хязгаарлахтай холбоотой бүлэг харилцаа.

Эдгээр бүлэг зохицуулалт нь Монголбанкны нэгдсэн хяналт шалгалтын талаар тус хуульд орсон хэм хэмжээг хэрэглэх болон банкны өмчлөл хэт монополь байдалтай болж банкны салбарын өрсөлдөөнийг хязгаарлах, ингэснээр харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашиг хохирохоос сэргийлэх суурь үндэслэл болох бөгөөд хүчингүй болсон Банкны тухай хуульд холбогдох этгээдийн хүрээг хэт явцуу тодорхойлж, тэдгээрийг бүхэлд нь хамарсан нэгдсэн хяналт шалгалт хийхтэй холбоотой харилцааг бүрэн зохицуулаагүйгээс үүдэлтэй практик үр дагаврыг дурдах шаардлагагүй биззэ...

Хоёр. Иргэн Д.Ламжав мэдээлэлдээ, Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.7, 36.11, 36.12 дахь хэсгүүд нь банкны хувьцаа эзэмшигчийн болон бусад этгээдийн өмчлөх эрхийг ноцтой хязгаарлаж, тэдгээрийг ялгаварлан гадуурхаж, эрх зүйн байдлыг үндэслэлгүйгээр дордуулан, улмаар тэгш эрхийн зарчмыг зөрчиж байгаа нь Үндсэн хуулийн

Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, ...Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалттай нийцэхгүй байна гэж үзжээ.

1. Үндсэн зарчмын 4-т "Нөлөө бүхий хувь нийлүүлэгчдийн бүтцийн өөрчлөлт -Банкны нөлөө бүхий хувьцаа буюу хяналтын эрхийг шууд болон шууд бусаар эзэмшиж буй этгээд уг эрхийг бусдад шилжүүлэхэд хянан шалгагч байгууллага нь хяналт тавих, шилжүүлэхээс татгалзах эрхтэй байх нь зүйтэй." гэж заасан байдаг.

Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт "Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт орохоор бол банк энэ талаар тухай бүр нь Монголбанкинд бичгээр мэдэгдэнэ." гэж заасан бол 36.2, 36.3, 36.4 дахь хэсгүүдэд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийн хувьд түүнээс харьцангуй хатуу журам үйлчлэхээр буюу Төв банкнаас урьдчилан зөвшөөрөл авахаар заасан нь үндэсний аюулгүй байдал, улс орны эдийн засагт банк, санхүүгийн салбарын гүйцэтгэх онцгой үүрэгтэй уялдсан, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид төдийгүй дотоодын ба олон улсын санхүүгийн тогтолцооны харилцан нягт уялдаатай байдлаас хамааран дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж буй Базелийн хорооноос баталсан дээрх зарчимд нийцсэн зохицуулалт болсон юм.

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд онцлог журам үйлчлэхээр Банкны тухай хуульд заасан явдал нь тэдгээрийг бусад хувьцаа эзэмшигчдээс ялгаварлан гадуурхсан хэрэг бус бөгөөд харин Монголбанк банкны системийг хянан зохицуулагчийн хувьд зөвхөн хувь нийлүүлсэн хөрөнгийн хүрээнээс хальж бусдаас татан төвлөрүүлсэн хадгаламж, хуримтлалын олон зуун тэрбумын хөрөнгөөр бизнесийн харилцаанд оролцдог хуулийн этгээдийн нөлөө бүхий томоохон эздийг хадгаламж эзэмшигч, харилцагчдын эрх ашгийн үүднээс ил тод байлгах, тэдгээрийн хөдөлгөөнд хяналт тавих үндсэн зорилго бүхий зохицуулалт юм.

2. Иргэн Д.Ламжав мэдээлэлдээ, Банкны тухай хуулийн дээрх зүйл, заалтууд нь Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг зөрчсөн бөгөөд ингэснээрээ Үндсэн хуулийн хуулиа дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим зөрчигдөнө гэж үзжээ. Гэвч Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт "Банк, санхүү, даатгал, үнэт цаасны салбарт компани үүсгэн байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон асуудлыг бусад хуулиар, нийтлэг асуудлыг энэ хуулиар тус тус зохицуулна." гэж заасан байдаг.

Банкны зохион байгуулалт-эрх зүйн хэлбэр, түүнд тавигдах тусгай шаардлага нь арилжааны банкны эрхлэх үйл ажиллагааны онцлогоос

хамааран нарийвчилсан хуулиар зохицуулагдана. Банк үнэт цаас гаргах түүнийг бусдад эзэмшүүлэх, тухайн үнэт цаасны өмчлөгч өөрчлөхтэй холбоотой харилцаа нь Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан нийтлэг асуудал гэхээс илүүтэй арилжааны банкууд санхүүгийн зах зээлд хөрөнгө татах банкны эрхлэх үйл ажиллагааны нэгэн хэлбэр болсон мэргэшлийн шинжтэй харилцаа юм.

3.Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11 дэх хэсэг нь тус хуулийн 22 дугаар зүйлд заасан гадаадын хөрөнгө оруулалттай банкинд үйлчилнэ. Тус заалтаар гадаадын хөрөнгө оруулалтыг банкны салбарт шууд хязгаарлаагүй бөгөөд гагцхүү гадаадын хөрөнгө оруулалттай банкны хувьцааг эзэмших этгээдийн талаар холбогдох мэдээллийг шаардан гаргуулах, хянан үзэх боломжийг бүрдүүлсэн. Энэ нь дээр дурдсан Базелийн хорооны "Банкны үр ашигтай хяналт шалгалтын Үндсэн зарчим"-ын 1-т заасантай нийцэж байгаа юм.

Тус зарчмын 1-т заасны дагуу банк байгуулах зөвшөөрөл олгох, түүнийг байнга хянан шалгах эрхийг хянан шалгах эрх бүхий байгууллагад олгосон банкны хяналт шалгалтын зохистой хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байхыг шаарддаг.

Аливаа улс оронд бодлогын шинжтэйгээр гадаадын хөрөнгө оруулалтыг зарим салбаруудад шууд хязгаарладаг /гадаадын хөрөнгө оруулагч хувьцаа эзэмших дээд хязгаарыг тогтоох гэх мэт/ бөгөөд энэ тухай холбогдох хууль тогтоомжууддаа тусгасан байдаг...

...Манай улсын хувьд Банкны тухай хуульд шууд хязгаарлалтын аргыг хэрэглээгүй бөгөөд гагцхүү хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тохиолдолд энэ нь нэг талаас үндсэний эрх ашгийг хөндөхүйц байдалд хүргэх үр дагавартай учир уг асуудлыг Төв банк хяналтдаа байлгаж, зөвшөөрөл өгөх нь зүйтэй гэж үзсэн.

4. Дэлхийн хэмжээнд банкны салбарын өрсөлдөөнийг дэмжих, зохистой засаглалыг бүрэн хэмжээнд нэвтрүүлэх, санхүүгийн зуучлал, зээл олголтыг зохистой хэмжээнд байлгах, түүнчлэн, банкны ашигт ажиллагаа, удирдлагын чанарыг муутгаж байдаг ашиг сонирхлын зөрчилдөөнийг бууруулах үүднээс санхүүгийн системийн хамгийн гол салбар болох банкны системийн хувь нийлүүлэгчдийн бүтцэд нилээд нухацтай хандаж, тодорхой хязгаарлалтуудыг хэрэглэдэг байна. Энэ үүднээс Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт "Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно." гэсэн заалт оруулсан билээ.

Ихэнх улс орнуудад банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн нэг этгээд болон түүний холбогдох этгээдийн хамтран эзэмшиж байгаа хувь хэмжээний дээд хязгаарыг тогтоож өгдөг. Тухайлбал, Тайландад арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас доошгүй хувийг хувийн салбарын нэг хөрөнгө оруулагч эзэмшихийг зөвшөөрдөг бол Чехэд үүнийг 20-иор хязгаарладаг байна. Харин Япон, Солонгос зэрэг орнуудад давхар эзэмшлийг хориглодог байна...

...Бусад орнуудтай харьцуулахад хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч нарт илүү уян хатан хандаж, нэг банкны томоохон хувь нийлүүлэгч байхад ямар нэг хязгаарлалт байхгүй бөгөөд харин өөр нэгэн банкны давхар эзэмшлийг хязгаарлаж байгаа билээ.

Хөрөнгө оруулагчийн ашиг сонирхлыг нэг банкинд төвлөрүүлснээр хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтойн зэрэгцээ том банкнаас нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Иймд Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.7, 36.11, 36.12 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй, харин ч Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг болон 4 дэх хэсэгт "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна." гэж заасантай бүрэн нийцсэн зохицуулалт болсон юм.

Гурав. Иргэн Д.Ламжав Банкны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.2 дахь заалт, 57.3 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн "Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана." гэсэнтэй нийцэхгүй байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчиж байна гэжээ.

Банкны тухай хуулийн дээрх заалтууд нь өмнө дурдсанчлан Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийн дагуу өөрөөр зохицуулагдсан хэлбэр бөгөөд энд санхүүгийн хэвийн байдалтай үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийг татан буулгах тухай бус, харин банкинд тавигдах өөрийн хөрөнгийн шалгуур үзүүлэлтийг 80-аас доош хувиар хангаж чадахгүй болсон арилжааны банкинд авах онцлог төрлийн албадлагын арга хэмжээний талаар зохицуулсан байна.

Арилжааны банкаас бусад бүх төрлийн ашгийн төлөө болон ашгийн бус хуулийн этгээдэд дампуурлын нэг хууль үйлчилдэг бөгөөд арилжааны банк төлбөрийн чадваргүй болох асуудал нь уг хуулийн үйлчлэлийн хүрээнд багтдаггүй. Иймд уг харилцааг нийтлэг зохицуулалтад

хамаарах ерөнхий ойлголт гэж үзэх нь буруу бөгөөд Банкны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.2, 57.3 дахь хэсэг нь Үндсэн хуульд нийцэж байна." гэжээ.

**Гурав. Мэдээлэл гаргагч Д.Ламжав 2010 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт хариу тайлбарыг ирүүлсэн байна. Үүнд:**

"...Нэг. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөс ирүүлсэн тайлбарт Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг батлахдаа хяналт шалгалтын хувьд Базелийн хорооны "Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим" хэмээх зөвлөмжийг удирдлага болгосон гэх тайлбарыг өгсөн байна.

Гэтэл Монгол Улс нь Базелийн хороонд албан ёсоор гишүүнээр элсээгүй тул уг хорооноос баталсан эрх зүйн баримт бичгийг дагаж мөрдөх үүрэг хүлээгээгүйн дээр түүнийг биелүүлээгүй гээд хууль зүйн үр дагавар бүхий аливаа хариуцлага хүлээх үндэслэлгүй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ" гэж заасан байдаг. Базелийн хорооны зөвлөмж нь Монгол Улсын олон улсын гэрээ биш юм.

Иймд Банкны тухай хуульд тусгагдсан боловч Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, зүйл, заалтыг зөрчсөн банкны хяналт шалгалтын тогтолцоог уг зөвлөмжийн шинжтэй зарчмуудаар зөвтгөх хууль зүйн үндэслэлгүй юм. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хувьд уг гэрээнд заасан үүргээ шударгаар биелүүлэх нь зүйн хэрэг. Үндсэн хуулийн үзэл баримтлал, үндэсний онцлог, эрх ашгийг харгалзан үзэхгүйгээр Монгол Улс гишүүнээр нэгдэн ороогүй олон улсын байгууллагаас баталсан зөвлөмжийн шинжтэй (зайлшгүй дагаж мөрдөх шинжтэй биш) баримт бичигт нийцүүлэн дотоодын хууль тогтоомжийг өөрчилснөөр нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар бүхий нөхцөл байдал үүсгэхээр байна.

Базелийн хорооны "Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим" хэмээх зөвлөмжийг хэрэгжүүлэх, баримтлах нэрийдлээр арилжааны банкны салбарт төрийн оролцоог хэт ихэсгэж, ингэснээр Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3-т заасан "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах", мөн зүйлийн 4-тзаасан "...хувийн аж ахуй эрхлэх" иргэний үндсэн эрхийг хязгаарласан

байна.

Хоёр. Банкны тухай хууль нь иргэний эдийн засгийн үндсэн эрх болох өмчлөх эрхийг хязгаарласан талаар тодорхой үндэслэл бүхий тайлбар хүргүүлсэн. Үүнийг Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт үгүйсгээгүй байх бөгөөд түүний тайлбарт "...банкны хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдтэй хамтран нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон үед тэдгээрийн хувьцаагаа захиран зарцуулахыг хязгаарлахтай холбоотой бүлэг харилцаа" хуульд бий гэснээр тодорхой илэрсэн байна. Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт "Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг", мөн зүйлийн 3.2 дахь хэсэгт "Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох" талаар хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмших нь өмчлөх эрх (хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, хувийн аж ахуй эрхлэх)-ээ хэрэгжүүлэх нэг хэлбэр болдог. Гэтэл иргэний энэхүү үндсэн эрхийг төрийн байгууллага, албан тушаалтан шууд хязгаарлах боломжийг Банкны тухай хуулиар олгосон байна.

Тухайлбал, Банкны тухай хуулийн Банкны хувьцааг эзэмших зөвшөөрөл олгох гэсэн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэгт "Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно" гэж зааснаар иргэний эд хөрөнгө өмчлөх, аж ахуй эрхлэх эрхийг ноцтойгоор зөрчиж байна. Энэ нь энгийн үгээр "нэг хүн 2 дэлгүүр ажиллуулж болохгүй" гэсэнтэй утга агуулга, мөн чанарын хувьд ижил байгаа юм. Түүгээр ч зогсохгүй цаашид "салбарын онцлог" гэх халхавчийн доор иргэний хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, хувийн аж ахуй эрхлэх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарладаг буруу жишиг тогтоох, ийм хуулийн орчин бүрдүүлэх эх үндсийг тавьж байгааг ч мөн анхааран үзэх хэрэгтэй.

Нөгөөтэйгүүр банкинд эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээнээс шалтгаалан нөлөө бүхий болон бусад гэсэн ангилал үүсгэн ялгаварлаж, тэгш байдлыг алдагдуулсан, улмаар нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл олгодоггүй бол өөр бусад банкинд хувьцаа эзэмших эрхийг шууд хязгаарласнаар алагчлан хандаж, Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "тэгш байдал... хангах... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн." гэснийг алдагдуулсан байна.

Аливаа иргэн аж ахуй эрхлэх замаар хөдлөх болон үл хөдлөх

эд хөрөнгө шударгаар олж авах үндсэн хэлбэр нь ашгийн төлөө хуулийн этгээд байгуулж түүнийхээ хувьцааг эзэмших явдал юм. Гэтэл эд хөрөнгө өмчлөх, хувьцаагаа захиран зарцуулах эрхийг хязгаарласнаар арилжааны банк нь бие даасан байдлаа хэт алдаж, Монголбанк нь арилжааны банкийг хянах биш өөрийн харьяа байгууллага шиг ажиллуулах хуулийн боломж бүрдсэн байна.

Гурав. Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг хэрэгжүүлж байгаа мэтээр тайлбар өгсөн байна.

Эдийн засгийг зохицуулна гэдэг нь иргэний өмчлөх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлана гэсэн үг биш, тэр дундаа хувийн хэвшлийн аж ахуй эрхлэх эрхийг хааж боогдуулах, түүнийг шалтгаангүй "зөвшөөрөлжүүлэх", хязгаарлах тухай асуудал биш юм..." гэжээ.

**Дөрөв.Мэдээлэл гаргагч Д.Ламжав 2010 оны 6 дугаар сарын 29-ны өдөр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч оролцуулах хүсэлтийг Үндсэн хуулийн цэцэд гаргасан бөгөөд үүндээ:**

"Банкны тухай хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэх Цэцийн дунд суудлын хуралдаанд иргэн Ц.Батсүхийг шинжээчээр оролцуулж өгөхийг хүсье." гээд нэр бүхий иргэний эзэмшсэн мэргэжил, эрхэлж буй ажлын талаар дурдсан бөгөөд энэхүү хүсэлтийг судлаад үзээд шинжээч томилох боломжгүй талаар мэдэгдсэн болно.

**Тав. Мэдээлэл гаргагч иргэн Д.Ламжав Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн гэсэн шаардлагаасаа, мөн Банкны тухай хуулийн мэдээлэлд дурдсан заалт нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3/ дахь хэсгийг зөрчсөн гэсэн шаардлагаасаа тус тус татгалзсан ба харин Банкны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.2, 57.3 дахь заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэсэн шаардлагыг нэмж гаргасан болно.**

**ҮНДЭСЛЭЛ:**

Улсын Их Хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан

Банкны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг Монгол Улсад банк үүсгэн байгуулах, банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах, банкны хувьцааг эзэмшихэд зөвшөөрөл олгох харилцааг тусгайлан зохицуулсан эрхзүйн хэм хэмжээг агуулсан хууль гэж үзэх үндэслэлтэй байна. Улс орны эдийн засагт банк, санхүүгийн салбарын гүйцэтгэх онцгой үүрэг, олон улсын банк, санхүүгийн тогтолцооны харилцан нягт уялдаатай байдал зэргийг харгалзан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зарчимд нийцүүлэн Монголбанкинд зөвшөөрөл олгох, хяналт тавих, албадлагын арга хэмжээ авах, эрсдлээс сэргийлэхтэй холбоотой зарим хязгаарлалт тогтоох эрх олгож хуульчилснаараа Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3/ дахь заалт, 36 дугаар зүйлийн 36.4, 36.12 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3/ дахь заалтыг, мөн 57 дугаар зүйлийн 57.1.2, 57.3 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3/ дахь заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаранзургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Банкны тухай хуулийн холбогдох этгээд гэсэн ойлголтыг тодорхойлсон 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван зургадугаар зүйлийн 3/-ын "хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. ..." гэснийг, 57 дугаар зүйлийн 57.1.2-т "банкийг хуулийн этгээдийнх нь хувьд албадан татан буулгаж энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу банкны актив хөрөнгийг захиран зарцуулах", 57.3 дахь хэсэгт "Банкинд бүтцийн өөрчлөлт хийх тухай төлөвлөгөө батлах боломжгүй гэж үзсэн, эсхүл энэ хуулийн 57.2-т заасны дагуу Монголбанкны шийдвэр гарснаас хойш зургаан сарын дотор банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө амжилтгүй хэрэгжсэн тохиолдолд Монголбанк нь банкийг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана." гэж заасан нь Үндсэн хуулийнТавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална."

гэснийг болон Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3/ дахь хэсгийн дээр дурдсан холбогдох заалтыг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэгт "Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт Монголбанкны зөвшөөрөлгүйгээр нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон нь хяналт шалгалтаар тогтоогдсон, эсхүл энэ хуулийн 36.12-т заасныг зөрчсөн бол уг этгээдийн тухайн хувьцааны саналын болон ногдол ашиг авах эрхийг түдгэлзүүлж, хувьцааг сүүлд авсан дарааллаар 30 хоногт багтаан хуульд заасан хязгаарлалтад хүрэх хэмжээнд албадан худалдахыг Монголбанк шаардах бөгөөд Монголбанкны зөвшөөрөлгүйгээр хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нэмж гарган худалдсан бол зөвшөөрөл аваагүй хувьцааны тоонд ногдох хэмжээг банкны өөрийн хөрөнгөөс хасч тооцно." гэсэн заалт, 36.12 дахь хэсэгт "Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно." гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3/ дахь хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ** **Ж.БЯМБАДОРЖ**

**ГИШҮҮД** **Н.ЖАНЦАН**

**Ж.АМАРСАНАА**

**Д.НАРАНЧИМЭГ**

**Ц.САРАНТУЯА**

**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420, 329612
Хэвлэлийн хуудас 3.75
**Индекс: 14003**



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас: 329487